



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЗАРИМ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ



Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн,
хүүхдэд олгох ортопед болон тусгай хэрэгслийн
үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ

УЛААНБААТАР ХОТ
2019 он

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

*Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох
ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт*

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,
Нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектор

Судалгааны багийн гишүүд:

М.Алтансүх	ХНХСИ-ийн захирал
Ч.Цогтбаяр	НХБСС-ын эрхлэгч
Б.Төмөрчулуун	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
М.Энхзориг	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын байр,

5 дугаар давхар

Утас: 77121286

Вэб хуудас: www.rilsp.gov.mn

Агуулга

Өмнөх үг	iv
Зургийн жагсаалт	v
Хүснэгтийн жагсаалт	vi
Товчилсон үгс	vii
Ойлголт, тодорхойлолт	vii
1 УДИРТГАЛ	1
1.1 Үндэслэл	1
1.2 Судалгааны зорилго, зорилт	1
2 АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	2
2.1 Судалгааны хамрах хүрээ	2
2.2 Судалгааны агуулга, үзүүлэлт	2
2.3 Түүврийн зохиомж	2
2.4 Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт	3
2.5 Судалгааны мэдээлэл цуглуулалт	3
2.6 Мэдээлэл боловсруулалт	3
3 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	4
3.1 Хууль, эрх зүйн зохицуулалт	4
3.2 Байгууллага сонгон шалгаруулах	5
3.3 Үйлчилгээний хамрагдалт	7
4 СУДАЛГААНЫ ҮР ДҮН	23
4.1 Үйлчилгээг хүртэгчид	23
4.1.1 Үйлчилгээнд хамрагдсан иргэд	23
4.1.2 Үйлчилгээнд хамрагдаагүй иргэд	29
4.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын төлөөлөл	31
4.2 Үйлчилгээг хэрэгжүүлэгчид	35
4.3 Нийлүүлэгч байгууллага	38
4.4 Ортопед болон тусгай хэрэгслийн үнэ	40
4.4.1 Нийлүүлэгч байгууллагын үнийн санал	42
5 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	45
5.1 Дүгнэлт	45
5.2 Санал, зөвлөмж	47

ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилт, түүний үр нөлөөг судлах, үйлчилгээг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зорилго бүхий судалгааг тогтмол хийдэг.

Энэ удаа ахмад настны тухай хуулийн 8.1.1-д зааснаар сонсох, харах эрхтний ортопед тусгай хэрэгсэл худалдан авсан болон дотоотод хийлгэсэн зардлын үнийг таван жилд нэг удаа нийгмийн халамжийн сангаас нөхөн олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.4-д зааснаар 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох үйлчилгээний хэрэгжилт, үр нөлөөг судлах, санал зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд “Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ – Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт” судалгааг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэн, үр дүнгийн тайланг танилцуулж байна.

Бид Улаанбаатар хотын 2 дүүрэг, 2 аймгийн 4 сумын хэмжээнд тус үйлчилгээг хүртэгч буюу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үйлчилгээг хэрэгжүүлэгч нийгмийн халамжийн мэргэжилтэн, ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагын төлөөллөөс чанарын судалгааны аргачлалын дагуу ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулж, судалгааг зохион байгууллаа.

Энэхүү судалгааны үр дүн нь уг үйлчилгээний талаар бодлого боловсруулагч болон бусад хэрэглэгчдэд холбогдох бодлого, хөтөлбөр боловсруулахад ашиглагдах суурь мэдээлэл болно гэж найдаж байна.

Судалгааг амжилттай зохион байгуулж, мэдээлэл цуглуулахад хамтарч ажилласан ХНХЯ, ХХҮЕГ болон аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн хамт олонд талархал илэрхийлье.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлалтай холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ



М.АЛТАНСҮХ

Зургийн жагсаалт

Зураг 1. Бүрдүүлэх материал	4
Зураг 2. <i>Үйлчилгээний хэрэгжиж буй бүтэц</i>	6
Зураг 3. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэн, зарцуулсан хөрөнгө, бүтцээр, 2019 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэл	9
Зураг 4. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, аймгаар, 2018 он.....	10
Зураг 5. Ахмад настан хамгийн их хамрагдсан ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ, бүтэц, аймгаар, 2018 он.....	11
Зураг 6. Улаанбаатар хотын ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, зарцуулсан хөрөнгө, дүүрэг, эзлэх хувиар, 2018 он.	12
Зураг 7. Ахмад настан хамгийн их хамрагдсан ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ, бүтэц, дүүргээр, 2018 он.....	13
Зураг 8. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг ахмад настанд ногдох дундаж зардал, аймгаар, 2018 он.....	14
Зураг 9. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, нэг ахмад настанд ногдох зардал, мян.төг, аймгаар, 2018 он.....	15
Зураг 10. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, нэг ахмад настанд ногдох зардал, мян.төг, дүүргээр, 2018 он.....	15
Зураг 11. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аймгаар, 2018 он	17
Зураг 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн их хамрагдсан ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ, бүтэц, аймгаар, 2018 он.....	18
Зураг 13. Улаанбаатар хотын ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зарцуулсан хөрөнгө, дүүрэг, эзлэх хувиар, 2018 он.	19
Зураг 14. Улаанбаатар хотын ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлчилгээний төрөл, эзлэх хувиар, 2018 он.....	20
Зураг 15. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн их хамрагдсан ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ, бүтэц, дүүргээр, 2018 он.....	20
Зураг 16. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ногдох дундаж зардал, аймгаар, 2018 он.....	21
Зураг 17. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, нэг ахмад настанд ногдох зардал, мян.төг, аймгаар, 2018 он.....	22
Зураг 18. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, нэг ахмад настанд ногдох зардал, мян.төг, дүүргээр, 2018 он.....	22
Зураг 19. СЗСҮТ, Эрхэм чанар ХХК-ны үнийн санал	43
Зураг 20. Ортопед, тусгай хэрэгслийн үнийг инфляцаар засварласан дүн	44

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: Ганцаарчилсан ярилцлагад хамрагдах иргэн	2
Хүснэгт 2. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэн, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр), төрлөөр	7
Хүснэгт 3. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, бүтцээр, 2018 он	8
Хүснэгт 4. Улаанбаатар хотын ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, зарцуулсан хөрөнгө, төрөл, хувиар, 2018 он	13
Хүснэгт 5. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, зарцуулсан хөрөнгө, төрөл, хувиар, 2018 он.....	16
Хүснэгт 6. Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ	40
Хүснэгт 7. Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ	41
Хүснэгт 8. Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ	42
Хүснэгт 9. Ортопед, тусгай хэрэгслийн үнийг инфляцаар засварласан дүн.....	44

ТОВЧИЛСОН ҮГС

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ЭХК	Эмнэлэг хяналтын комисс
ТББ	Төрийн бус байгууллага
МХҮХ	Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо
НХҮНМС	Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем
СЗСҮТ	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Ортопедийн хэрэгсэл – Харааны шил, +5, -5 болон түүнээс дээш контакт линз, сонсголын дижитал аппарат, согог засах бүх төрлийн гутал (өвөл, зун, хавар, намар), нурууны хамгаалалт (ширэн, даавуун, хуванцар), нурууны бэхэлгээ, төрөл бүрийн гар, хөлийн болон суга өргөгч чиг (урт, богино, хөлийн аппарат), хараагүй хүний таяг болон бусад төрөл бүрийн таяг, хүзүүвч, хүзүүний бэхэлгээ (хатуу, зөөлөн) павликийн дөрөөвч, ивэрхийн даруулга, алхуулагч, төрөл бүрийн улавч, дунд чөмөгний болон шилбэний порлон.¹

Тусгай хэрэгсэл – Тэргэнцэр, алхуулагч, толгой өргөгчтэй сандал, хүүхдийн цээживч, булангийн сандал, хэвтүүлэгч, зогсоогч, гар хөлний спилень, хараагүй хүний хэрэгсэл, стомын уут, суултуур, хөтөвч, бусад тусгай хэрэгсэл.²

¹ <http://hudulmur-halami.gov.mn>

² Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он.

1 УДИРТГАЛ

1.1 Үндэслэл

Монгол улсад 2018 оны эцсийн байдлаар 291.7³ мянган ахмад настан⁴, 105.7⁵ мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн⁶ байгаа бөгөөд эдгээр иргэдийн амьжиргааг дэмжиж, нийгмийн хамгааллыг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлдэг.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилт, түүний үр нөлөөг судлах, үйлчилгээг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зорилгоор “Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үнэлгээ”-г хөтөлбөр бүр дээр хийхийг зорьж байгаа билээ.

Ахмад настны тухай хуулийн 8.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1-т зааснаар хөл, гарны протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг нийгмийн халамжийн сангаас олгодог бөгөөд 2018 оны байдлаар 48.2 мянган иргэнд 5.2 тэрбум төгрөгийн ортопедийн хэрэгслийн үнийг олгосон байна.

Дээрх хуулийн заалттай холбоотойгоор Засгийн газраас “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ тогтоох тухай” тогтоол гаргадаг бөгөөд хамгийн сүүлд 2017 оны 11 сарын 24-ний өдрийн 316-р тогтоолоор шинэчилсэн. Гэвч уг тогтоолд жагсаалтыг шинэчилсэн боловч үнийг шинэчлээгүй. Үнэ, тариф болон амьжиргааны өртгийн өөрчлөлтийг харгалзан жишиг үнийн хэмжээнд тухай бүрт өөрчлөлт оруулах санал боловруулж Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж байхыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан байдаг боловч жагсаалтад байгаа 2012 оны жишиг үнэ өөрчлөгдөөгүй байна.

Иймд уг үйлчилгээний талаар тухайн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн санал бодол, хэрэгжилтийн үеийн хүндрэл бэрхшээл, хөтөлбөр хэр үр нөлөөтэйг судлах шаардлагын үүднээс энэхүү судалгааг хийлээ.

1.2 Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үр нөлөөг судлах, хөтөлбөрийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

1. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоон мэдээлэлд шинжилгээ хийх;
2. Ортопед болон тусгай хэрэгслийн чанар, стандартын талаар судлах;
3. Ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлтийн үйлчилгээний хэрэгжилтэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох;
4. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт эдэлсэн иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох;
5. Үйлчилгээг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах.

³ ҮСХ, www.1212.mn

⁴ Ахмад настны тухай хуулийн 3.1-д зааснаар 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй Монгол улсын иргэн хамаарна.

⁵ ҮСХ, www.1212.mn

⁶ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамаарна.

2 АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Судалгааны хамрах хүрээ

Судалгааг байршлын хувьд ялгаа бүхий 2 аймаг (алслагдмал болон ойр) сонгосон. Мөн хот хөдөөгийн ялгааг тодруулах үүднээс аймаг тус бүрт аймгийн төвийн болон алслагдмал нэг сумыг сонгосон. Нийслэлийн хувьд ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамгийн их хамрагдсан хоёр дүүргийг сонгож дараах иргэдээс ганцаарчилсан ярилцлагын аргаар чанарын судалгааг авсан. Үүнд:

- *Үйлчилгээг хүртээгч* буюу
 - Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан болон хамрагдах боломжтой ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлж буй ТББ;
- *Үйлчилгээг хэрэгжүүлэгч* буюу
 - Хөдөлмөр, нийгмийн халамжийн газар/хэлтсийн ажилтан;
 - Ортопед болон тусгай хэрэгсэл үйлдвэрлэдэг болон нийлүүлэхээр ХХҮЕГ-тай гэрээ байгуулсан байгууллага

2.2 Судалгааны агуулга, үзүүлэлт

Судалгааг дараах үндсэн 2 агуулгын хүрээнд зохион байгуулсан. Үүнд:

- Ортопед болон туслах хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн өнөөгийн байдлыг тодорхойлох;
- Ортопед болон туслах хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг сайжруулах боломжийг тодорхойлох.

2.3 Түүврийн зохиомж

Хүн амын тоотой харьцуулахад ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамгийн их хамрагдалттай алслагдмал болон ойр 2 аймаг, нийслэлийн төвийн болон алслагдмал 2 дүүрэг сонгон үйлчилгээнд хамрагдсан иргэд, үйлчилгээг хэрэгжүүлэгчдээс чанарын судалгааг ганцаарчилсан ярилцлагын аргаар авсан.

Хүснэгт 1: Ганцаарчилсан ярилцлагад хамрагдах иргэн

	Улаанбаатар		Завхан		Өвөрхангай		Нийт
	Чингэлтэй	Налайх	Улиастай	Яруу сум	Арвайхээр	Зүүнбаян-Улаан	
Ганцаарчилсан ярилцлага							
Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн /ХНХЯ/	1						1
Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн /ХХҮЕГ/	2						2
Аймаг, дүүргийн ХХҮГ/хэлтсийн мэргэжилтэн	2	2	2		2		8
Сум/хорооны халамжийн мэргэжилтэн	2	2	1	1	1	1	8
Ортопед болон тусгай хэрэгсэл нийлүүлэхээр гэрээ байгуулсан байгууллага	6		2		2		10

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт авсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд	12	12	12	6	12	6	60
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын төлөөлөл	3						3
Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт аваагүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд	6	6	6	3	6	3	30
	34	22	23	10	23	10	122

2.4 Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт

Судалгааны хөтөлбөр боловсруулах, чиглүүлэх асуултууд бэлтгэх, асуултуудыг турших зэрэг судалгааны бэлтгэл ажлыг 2019 оны 6 дугаар сараас эхлүүлсэн.



2.5 Судалгааны мэдээлэл цуглуулалт

Судалгааг батлагдсан удирдамжийн дагуу ХНХСИ-ийн захирлын 2019 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн А/18 тушаалаар судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2019 оны 8 дугаар сарын 5-ны өдөр эхлүүлж, 2 үе шаттайгаар явуулсан.

Эхний шат: 2019 оны 8 дугаар сарын 05-ны өдрөөс 8 дугаар сарын 20-ны хооронд орон нутагт буюу Завхан аймгийн Улиастай, Яруу сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Зүүнбаян-Улаан сумдуудаас үйлчилгээнд хамрагдсан болон хамрагдах хүсэлтэй иргэд, ХХҮГ-ын мэргэжилтнүүд, ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагыг хамруулан судалгааг авсан.

Хоёр дахь шат: 2019 оны 8 дугаар сарын 21-нээс 28-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Чингэлтэй, Налайх дүүргийн үйлчилгээнд хамрагдсан болон хамрагдах хүсэлтэй иргэд, ХХҮХ-ийн мэргэжилтэн, ортопед болон тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагаас мэдээлэл цуглуулсан. Мөн ХХҮЕГ-ын мэргэжилтэн, ХНХЯ-ны НХБХЗГ-ын мэргэжилтэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын төлөөллийн гишүүдтэй ярилцлага хийж, ортопед, тусгай хэрэгслийн үнийн саналын мэдээллийг цуглуулсан.

2.6 Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээлэл боловсруулалтын хүрээнд цуглуулсан мэдээллийг шивэх, тоон мэдээллийг нэгтгэх, мэдээлэлд шинжилгээ хийх ажлууд хийгдсэн. Мэдээлэл шивэлт, мэдээлэл боловсруулалт, тайлан бичилтийн ажил 9 дүгээр сарын 2-ны өдрөөс 10 дугаар сарын 11-ны хооронд үргэлжилсэн.

3 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.1 Хууль, эрх зүйн зохицуулалт

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийгмийн халамжийн сангаас олгохоор хуульчлан заасан байдаг бөгөөд дараах хуулийн заалтуудаар зохицуулагддаг. Үүнд:


Ахмад настны тухай хуулийн 8.1.1-д зааснаар сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг таван жилд нэг удаа нийгмийн халамжийн сангаас нөхөн олгох.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.4-д зааснаар 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох.⁷

Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн “Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнийг тогтоох тухай” 153 дугаар тогтоолоор батлагдсан үнийн дагуу нийлүүлэгч байгууллагууд ортопед, тусгай хэрэгслийг нийлүүлдэг ба 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Засгийн газрын 316 дугаар тогтоолоор жагсаалт шинэчлэгдсэн ч ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэд өөрчлөлт ороогүй байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчилгээнд хамрагдахын тулд дараах материалуудыг бүрдүүлдэг.

Зураг 1. Бүрдүүлэх материал



⁷ Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019 он.

3.2 Байгууллага сонгон шалгаруулах

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чанарын шаардлага хангасан ортопед болон тусгай хэрэгсэл нийлүүлэх байгууллагын жагсаалтыг ХХҮЕГ-аас гаргадаг ба дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байгууллагуудыг сонгон шалгаруулдаг байна.

- Байгууллагын албан хүсэлт /ямар төрлийн ортопедийн болон тусгай хэрэгсэл нийлүүлэхээр жагсаалтад орох тухай санал, бүтээгдэхүүн тус бүрээр үнийн санал, дэлгэрэнгүй хаяг, байршил, холбоо барих утас/
- Байгууллагын танилцуулга
- Улсын бүртгэлийн гэрчилгээ нотариатаар батлуулсан хуулбар
- Татварт өргүйг тодорхойлсон шүүхийн байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын байгууллагад өргүйг тодорхойлсон тодорхойлолт
- Өмнөх жилийн санхүүгийн баталгаажсан тайлан
- Үйл ажиллагаа явуулах өөрийн болон түрээсийн байртайг нотолсон бичиг /Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй зорчих стандарт орчин бүрдүүлсэн байх, бүтээгдэхүүн хадгалах тусдаа агуулах савтай байх/
- Хүний нөөцийн талаархи мэдээлэл /иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар/
- Баримт бичгийн товъёог хийж, бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, байгууллагын тамгаар баталгаажуулсан байх
- Ортопедийн болон тусгай хэрэгсэлд 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгөх бөгөөд энэ хугацаанд засвар үйлчилгээг хариуцан хийх
- Бүрдүүлсэн баримт бичгүүд үнэн бодитой байх

Ортопедийн болон тусгай хэрэгсэл гадаадаас импортоор оруулж ирдэг байгууллага

- Улсын бүртгэлийн гэрчилгээнд ортопедийн болон тусгай хэрэгсэл импортлох эсхүл гадаад худалдаа эрхлэх зөвшөөрөлтэй байх
- Үйлдвэрлэгч байгууллага эсхүл түүний гэрээт борлуулагчтай байгуулсан гэрээний хуулбар
- Гэрээ байгуулсан үйлдвэрийн үйлдвэрлэсэн ортопедийн болон тусгай хэрэгсэл нь олон улсын стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг нотлох баримт бичиг

Ортопедийн болон тусгай хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэдэг байгууллага


- Ортопедийн болон тусгай хэрэгсэл үйлдвэрлэх зөвшөөрөл
- Үйлдвэрлэсэн ортопедийн болон тусгай хэрэгсэл зохих стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг нотлох баримт бичиг
- Тоног төхөөрөмжийн мэдээлэл

Дээрх шалгуурыг хангасан байгууллагатай гэрээ байгуулдаг бөгөөд гэрээнд захиалагчийн эрх, үүрэг, гүйцэтгэгчийн эрх, үүрэг, гэрээний хариуцлага, хугацааг тодорхой зааж өгсөн байна. 2018 онд 56 байгууллага ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлж байсан бол 2019 онд нийт 79 байгууллага санал ирүүлснээс 69 байгууллагатай гэрээ байгуулж хамтарч ажиллаж байна.

Ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдах шаардлагатай иргэд дээрх жагсаалтад багтсан байгууллагаас өөрт шаардлагатай хэрэгслийг авах боломжтой. Алслагдмал дүүргийн иргэд (Налайх, Багануур, Багахангай) тухайн дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг ортопед болон тусгай хэрэгсэл нийлүүлдэг байгууллага байхгүй тул Улаанбаатар хотод ирж авдаг.

Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд жагсаалтад багтсан, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас ортопед, тусгай хэрэгслээ авдаг бөгөөд тухайн байгууллагад байхгүй хэрэгслийг Улаанбаатар хотод ирж авах боломжтой байдаг.

Зураг 2. Үйлчилгээний хэрэгжиж буй бүтэц



Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүнд шаардлага хангасан ортопедийн болон тусгай хэрэгсэл нийлүүлэх байгууллагаас татгалзах үндэслэл

- Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй
- Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон
- Сүүлийн 3 жилийн хугацаанд Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон
- Илт худал мэдээлэл бүхий материал ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон
- Нийтлэг болон тусгай шалгуурыг хангаагүй

2019 оноос ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлж байгаа байгууллагуудтай гэрээ байгуулдаг болсон ба гэрээнд гүйцэтгэгч талын эрх, үүргийг тодорхой зааж өгснөөр хариуцлага тооцох боломжтой болсон байна.

2019 онд 69 байгууллагатай гэрээ байгуулсан. Орон нутгийн иргэд тухайн аймагтаа гэрээ байгуулсан байгууллагаас ортопед болон тусгай хэрэгслээ авах, орон нутагт гэрээ байгуулсан байгууллага байхгүй бол Улаанбаатар хотод ирж авдаг. Ортопед болон тусгай хэрэгсэл нийлүүлэх бүх байгууллагатай гэрээ байгуулсан. Гэрээний заалтад байгууллага зохион байгуулалттай сумдаар, хороодоор явж ортопед, тусгай хэрэгсэл тараах үйл ажиллагаа явуулахгүй байх гэдгийг тусгаж өгсөн. 2018 онд гэрээ байгуулдаггүй байсан тул 2019 оноос зааж өгдөг болсон. Одоогоор ортопед, тусгай хэрэгслийг нийлүүлэгч байгууллага тараах үйл ажиллагаа зохион байгуулж байна гэсэн гомдол ирээгүй байна.⁸

⁸ ХХҮЕГ-ын Ахмад настны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

3.3 Үйлчилгээний хамрагдалт

2018 оны жилийн эцсийн байдлаар ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд нийт 48 193 иргэн хамрагдаж өмнөх оноос 13 086 (37.3 хувь) иргэнээр нэмэгдсэн байна. Үйлчилгээнд хамрагдсан ахмад настан 75.5 хувиар нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 22.1 хувиар буурч өөрчлөлтөд нөлөөлсөн байна. Нийт хамрагдсан иргэдийн 77.8 хувь нь ахмад настан, 22.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. 2019 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 18 778 иргэн хамрагдсан бөгөөд хамрагдсан иргэдийн 80.9 хувь нь ахмад настан, 19.1 хувь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Манай Улсад 2018 оны жилийн эцсийн байдлаар 291.7 мянган ахмад настан (эрэгтэй 60 ба түүнээс дээш, эмэгтэй 55 ба түүнээс дээш), 105.7 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Тухайн дүнд үндэслэн тооцоолол хийж үзэхэд, нийт ахмад настны 12.9 хувь, нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10.1 хувь нь ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан байна.

Хүснэгт 2. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэн, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр), төрлөөр

Үзүүлэлт	2017		2018		2019 (I-VII)	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
Ахмад настан	21 362	2 519.8	37 490	3 478.5	15 185	1 254.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	13 745	2 101.9	10 703	1 730.2	3 593	549.3
Нийт	35 107	4 621.6	48 193	5 208.6	18 778	1 803.7

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

2018 оны жилийн эцсийн байдлаар ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдэд 5 208.6 сая төгрөг зарцуулж өмнөх оноос 587.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. 2018 онд ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нийт иргэдийн 77.8 хувь нь ахмад настан байгаа бол нийт зарцуулсан хөрөнгийн 66.8 хувийг ахмад настанд зарцуулсан байна. Энэ нь ахмад настанууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бодвол бага үнэтэй ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээнд хамрагдсан байна. 2019 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 15185 ахмад настан 1 254.4 сая төгрөгийн үйлчилгээ авсан бол 3593 хөгжлийн бэрхшээлтэй иргэн 549.3 сая төгрөгийг үйлчилгээ авсан байна.

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дунджаар 2017 онд 152 921 төгрөг зарцуулж байсан бол 2018 онд 161 656 төгрөг зарцуулж өмнөх оноос 8 735 төгрөгөөр өссөн байна. Харин 2019 оны хагас жилийн урьдчилсан байдлаар нэг хүнд дунджаар 152 881 төгрөг зарцуулж байгаа нь 2018 оны жилийн эцэстэй харьцуулахад 8 775 төгрөгөөр бага байна. Харин ахмад настанд дунджаар 2017 онд 117 957 төгрөг зарцуулж байсан бол 2018 онд 92 785 төгрөг, 2019 оны хагас жилийн урьдчилсан байдлаар 82 608 төгрөг зарцуулсан байна.

Зураг 3. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг хүнд ногдох дундаж зардал, төрлөөр



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

АХМАД НАСТАН

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 2018 онд нийт

37 490 ахмад настанд 3 478.5 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үйлчилгээнд хамрагдсан ахмад настан өмнөх оны мөн үеээс 16 128 (75.5 хувь) иргэнээр, зарцуулсан хөрөнгө 958.7 (38.0 хувь) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. 2019 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 15 185 ахмад настанд, 1 254.4 сая төгрөгийн ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг үзүүлсэн байна.

2018 онд ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нийт ахмад настануудыг үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл, 18.5 хувь нь өвдгөвч (баруун 10.4 хувь, зүүн 8.1 хувь), 17.0 хувь нь хөтөвч, суултуур, 11.5 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 9.9 хувь нь нурууны даавуун хамгаалалт, 9.8 хувь нь сонсголын дижитал аппарат, 8.7 хувь нь харааны шил, 6.7 хувь нь гар таяг, 5.4 хувь нь тэргэнцэр, 3.9 хувь нь тохойн тулгууртай хос таяг, 2.2 хувь нь алхуулагч авсан байна.

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмадуудад зарцуулсан хөрөнгийг үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл, зарцуулсан хөрөнгийн 37.5 хувь нь сонсголын дижитал аппарат, 16.4 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 14.7 хувь нь хөтөвч, суултуур, 8.9 хувь нь тэргэнцэр, 6.4 хувь нь нурууны даавуун хамгаалалт, 3.0 хувь нь өвдгөвч, 2.6 хувь нь алхуулагч, 1.6 хувь нь хүзүүвч, 1.4 хувь нь харааны шил, 1.3 хувь нь тохойн тулгууртай таяг (хос), үлдсэн 6.2 хувь нь бусад үйлчилгээнд зарцуулагдсан байна.

Хүснэгт 3. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, бүтцээр, 2018 он


Үйлчилгээний төрөл	Олгосон хүний тоо	Эзлэх хувь	Үйлчилгээний төрөл	Зарцуулсан дүн, сая төгрөг	Эзлэх хувь
Нийт	37490	100	Нийт	3478.5	100
Өвдгөвч (баруун, зүүн)	6950	18.5	Сонсголын дижитал аппарат	1304.8	37.5
Хөтөвч, суултуур	6392	17.0	Нурууны ширэн хамгаалалт	569.6	16.4
Нурууны ширэн хамгаалалт	4293	11.5	Хөтөвч, суултуур	510.4	14.7
Нурууны даавуун хамгаалалт	3728	9.9	Тэргэнцэр	307.9	8.9
Сонсголын дижитал аппарат	3671	9.8	Нурууны даавуун хамгаалалт	223.2	6.4

Харааны шил	3244	8.7	Өвдгөвч (баруун, зүүн)	104.6	3.0
Гар таяг	2508	6.7	Нурууны хуванцар хамгаалалт	91.9	2.6
Тэргэнцэр	2010	5.4	Хүзүүвч	54.7	1.6
Тохойн тулгууртай таяг (хос)	1478	3.9	Харааны шил	48.6	1.4
Алхуулагч	843	2.2	Тохойн тулгууртай таяг (хос)	46.8	1.3
Бусад	2373	6.3	Бусад	216.1	6.2

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

2019 оны хагас жилийн байдлаар нийт үйлчилгээнд хамрагдсан ахмад настны 17.8 өвдгөвч (баруун 13.4 хувь, зүүн 5.3 хувь), 16.8 хувь нь хөтөвч, суултуур, 13.2 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 10.5 хувь нь нурууны даавуун хамгаалалт, 10.3 хувь нь харааны шил, 7.3 хувь нь гар таяг, 6.1 хувь нь сонсголын дижитал аппаратыг авсан байна. Зарцуулсан хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 25.9 хувийг сонсголын дижитал аппарат, 23.0 хувийг нурууны ширэн хамгаалалт, 16.3 хувийг хөтөвч, суултуур, 9.0 хувийг тэргэнцэр, 7.6 хувийг нурууны даавуун хамгаалалт, үлдсэн 18.2 хувийг бусад үйлчилгээнд зарцуулсан байна.


Зураг 3. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэн, зарцуулсан хөрөнгө, бүтцээр, 2019 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэл



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

2018 оны байдлаар ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан ахмад настны 19 111 (51.0 хувь) нь орон нутгаас, 18 379 (49.0 хувь) нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас хамрагдсан нийт ахмад настны 16.8 хувь нь Завхан, 14.8 хувь нь Ховд, 13.7 хувь нь Дундговь, 11.8 хувь нь Хэнтий аймгаас, 6.8 хувь нь Архангай аймгуудаас хамрагдсан байна. Мөн тус үйлчилгээнд хамрагдсан ахмад настанд зарцуулсан нийт хөрөнгийн 1 700 сая төгрөг (48.9 хувь) нь орон нутагт, 1 778.5 сая төгрөг (51.1 хувь) нь Улаанбаатар хотод зарцуулагдсан байна. Орон нутгийн зардлын 13.8 хувийг Хөвсгөл, 10.7 хувийг Ховд, 10.7 хувийг Завхан, 7.9 хувийг Дархан-Уул, 6.8 хувийг Архангай аймгуудад зарцуулсан байна.

Зураг 4. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, аймгаар, 2018 он



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настануудыг аймгаар, хамгийн их авсан тусгай хэрэгслийн төрлөөр авч үзвэл:

Өвдгөвч авсан ахмад настны 44.8 хувь нь орон нутгаас, 55.2 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас өвдгөвч авсан ахмад настны 45.8 хувь нь Завхан, 32.0 хувь Дундговь, 8.9 хувь нь Ховд, 6.9 хувь нь Архангай аймгаас хамрагдаж авсан байна.

Хөтөвч, суултуур авсан ахмад настны 48.1 хувь нь орон нутгаас, 51.9 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас суултуур, өвдгөвч авсан ахмад настны 19.8 хувь нь Хөвсгөл, 12.0 хувь нь Ховд, 10.7 хувь нь Дундговь аймгаас хамрагдсан байна.


Нурууны ширэн хамгаалалт авсан ахмад настны 49.8 хувь нь орон нутгаас, 50.2 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас нурууны ширэн хамгаалалт авсан ахмад настны 33.5 хувь нь Хөвсгөл, 29.1 хувь нь Завхан, 10.3 хувь нь Дундговь, 7.9 хувь нь Төв аймгаас хамрагдсан байна.

Нурууны даавуун хамгаалалт авсан ахмад настны 63.8 хувь нь орон нутгаас, 36.2 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас нурууны даавуун хамгаалалт авсан ахмад настны 21.4 хувь нь Ховд, 18.3 хувь нь Дундговь, 10.9 хувь нь Завхан, 10.8 хувь нь Өвөрхангай, 7.9 хувь нь Орхон аймгаас хамрагдсан байна.

Сонсголын дижитал аппарат авсан ахмад настны 50.0 хувь нь орон нутгаас, 50.0 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас сонсголын аппарат авсан ахмад настны 15.6 хувь нь Дархан-Уул, 12.8 хувь нь Хөвсгөл, 10.1 хувь нь Хэнтий, 9.4 хувь нь Архангай, 9.1 хувь нь Дорнод аймгаас хамрагдсан байна.

Харааны шил авсан ахмад настны 69.8 хувь нь орон нутгаас, 30.2 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас харааны шил авсан ахмад настны 29.3 хувь нь Ховд, 17.0 хувь нь Дорнод, 14.7 хувь нь Завхан, 10.2 хувь нь Өвөрхангай, 7.9 хувь нь Дундговь аймгаас хамрагдсан байна.


Зураг 5. Ахмад настан хамгийн их хамрагдсан ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ, бүтэц, аймгаар, 2018 он



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

2018 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд 18 379 ахмад настан хамрагдаж, 1 778.5 сая төгрөг зарцуулсан байна. Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нийт ахмад настны 26.2 хувь нь Чингэлтэй, 15.8 хувь нь Сүхбаатар, 15.3 хувь нь Баянзүрх, 13.7 хувь нь Хан-Уул, 12.2 хувь нь Сонгинохайрхан, 8.7 хувь нь Баянгол, үлдсэн 8.1 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүргүүдээс хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгөөр нь авч үзвэл, 19.7 хувийг Чингэлтэй, 15.2 хувийг Баянзүрх, 15.1 хувийг Сүхбаатар, 15.0 хувийг Сонгинохайрхан, 14.9 хувийг Хан-Уул, 12.2 хувийг Баянгол дүүргүүдэд зарцуулсан байна.

Зураг 6. Улаанбаатар хотын ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, зарцуулсан хөрөнгө, дүүрэг, эзлэх хувиар, 2018 он.



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нийт ахмад настнуудыг хамгийн их авсан хэрэгслийн төрлөөр нь авч үзвэл, 20.8 хувь нь өвдгөвч (баруун 11.8 хувь, зүүн 10.8 хувь), 18.1 хувь нь хөтөвч, суултуур, 11.7 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 10.0 хувь нь сонсголын дижитал аппарат, 7.3 хувь нь нурууны даавуун хамгаалалт, 6.9 хувь нь гар таяг, 5.8 хувь нь тэргэнцэр, 5.3 хувь нь харааны шил, 5.2 хувь нь тохойн тулгууртай хос таяг, 3.1 хувь нь алхуулагч авсан байна. Харин үйлчилгээнд хамрагдсан ахмадуудад зарцуулсан хөрөнгийг үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл, зарцуулсан хөрөнгийн 36.2 хувь нь сонсголын дижитал аппарат, 17.0 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 14.9 хувь нь хөтөвч, суултуур, 9.0 хувь нь тэргэнцэр, 4.9 хувь нь нурууны хуванцар хамгаалалт, 4.5 хувь нь нурууны даавуун хамгаалалт, 3.2 хувь нь өвдгөвч, 1.8 хувь нь тохойн тулгууртай таяг(хос), 1.6 хувь нь стомын уут, 1.6 хувь нь алхуулагч, үлдсэн 5.2 хувь нь бусад үйлчилгээнд зарцуулагдсан байна.

Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлтөд хамрагдсан 5 ахмад настан бүрийн 1 нь өвдгөвч авч байгаа бөгөөд зарцуулж буй дүн маш бага байна. Харин 10 ахмад бүрийн нэг нь сонсголын дижитал аппарат авч байгаа нь бага хэдий ч зарцуулж буй мөнгөн дүн нь бусад хэрэгслээс өндөр байна.


Хүснэгт 4. Улаанбаатар хотын ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, зарцуулсан хөрөнгө, төрөл, хувиар, 2018 он

Үйлчилгээний төрөл	Олгосон хүний тоо	Эзлэх хувь	Үйлчилгээний төрөл	Зарцуулсан дүн, сая төгрөг	Эзлэх хувь
Нийт	18379	100	Нийт	1778.5	100.0
Өвдгөвч	3827	20.8	Сонсголын дижитал аппарат	644.7	36.2
Хөтөвч, суултуур	3320	18.1	Нурууны ширэн хамгаалалт	303.1	17.0
Нурууны ширэн хамгаалалт	2157	11.7	Хөтөвч, суултуур	265.6	14.9
Сонсголын дижитал аппарат	1835	10.0	Тэргэнцэр	159.6	9.0
Нурууны даавуун хамгаалалт	1350	7.3	Нурууны хуванцар хамгаалалт	86.4	4.9
Гар таяг	1269	6.9	Нурууны даавуун хамгаалалт	80.9	4.5
Тэргэнцэр	1064	5.8	Өвдгөвч	57.5	3.2
Харааны шил	979	5.3	Тохойн тулгууртай таяг	31.2	1.8
Тохойн тулгууртай таяг	963	5.2	Насанд хүрэгсдийн стомын уут /50ш/	28.8	1.6
Алхуулагч	575	3.1	Алхуулагч	28.8	1.6
Бусад	1040	5.7	Бусад	92.0	5.2

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдаж өвдгөвч авсан 5 ахмад бүрийн хоёр нь (39.9 хувь) Чингэлтэй дүүргээс, хөтөвч суултуур авсан 5 ахмад бүрийн нэг нь (23.6 хувь) Чингэлтэй дүүргээс, нурууны ширэн хамгаалалт авсан 3 ахмад бүрийн нэг нь (32.3 хувь) Чингэлтэй дүүргээс, сонсголын дижитал аппарат авсан 5 ахмад бүрийн нэг нь (20.9 хувь) Сонгинохайрхан дүүргээс хамрагдсан байна.

Зураг 7. Ахмад настан хамгийн их хамрагдсан ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ, бүтэц, дүүргээр, 2018 он




Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг ахмад настанд ногдох дундаж зардлыг тооцож үзэхэд 92.8 мянган төгрөг байна.

Аймгуудын нэг ахмад настанд ногдох дундаж зардлыг тооцож үзэхэд Хэнтий аймаг 253.3 мянган төгрөг, Дорноговь аймаг 204.2 мянган төгрөг, Дархан-Уул аймаг 173.3 мянган

төгрөг, Өмнөговь аймаг 157.7 мянган төгрөг, Говьсүмбэр аймаг 145.4 мянган төгрөг, Увс аймаг 125.1 мянган төгрөг, Сэлэнгэ аймаг 122.0 мянган төгрөг, Баянхонгор аймаг 117.2 мянган төгрөг, Говь-Алтай аймаг 115.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.


Зураг 8. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг ахмад настанд ногдох дундаж зардал, аймгаар, 2018 он



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Тус үйлчилгээнд хамгийн их ахмад настан хамрагдсан Дундговь, Завхан, Ховд аймгуудын хувьд нэг ахмад настанд ногдох зардал нь хамгийн бага байна. Дундговь аймгаас хамрагдсан 3 ахмад настан бүрийн нэг нь (38.2 хувь), Завхан аймгаас хамрагдсан 5 ахмад настан бүрийн хоёр нь (44.5 хувь) өвдгөвч авсан байна. Ховд аймгаас хамрагдсан 5 ахмад настан бүрийн нэг нь (23.4 хувь) харааны шил, 10 ахмад настан бүрийн нэг нь өвдгөвч авсан байна. Хамгийн бага хүн хамрагдсан Дорноговь, Өмнөговь, Хэнтий аймгуудын хувьд нэг ахмад настанд ногдох дундаж зардал нь улсын дунджаас 0.5-2 дахин их байна. Өөрөөр хэлбэл тухайн аймгуудын ахмадууд үнийн дүн өндөртэй үйлчилгээнд их хамрагдсан байх магадлалтай байна.


Зураг 9. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, нэг ахмад настанд ногдох зардал, мян.төг, аймгаар, 2018 он.



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг ахмад настанд ногдох дундаж зардлыг тооцож үзэхэд Улаанбаатар хотын дундаж 96.8 мянган төгрөг байна. Хамгийн их ахмад настан хамрагдсан Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдийн хувьд Улаанбаатар хотын дунджаас бага мөнгө зарцуулсан байна. Тухайн дүүргүүдийн ахмадууд үнийн дүн багатай үйлчилгээнд их хамрагдсан байх магадлалтай байна.

Зураг 10. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, нэг ахмад настанд ногдох зардал, мян.төг, дүүргээр, 2018 он.



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН

Манай Улсад 2018 оны жилийн эцсийн байдлаар 105.7 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 56.5 хувь нь эрэгтэйчүүд, 43.5 нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь авч үзэхэд, 11.5 мянга (10.9 хувь) нь харааны, 4.3 мянга (4.8 хувь) нь ярианы, 8.4 мянга (8.0 хувь) нь сонсголын, 21.6 мянга (20.4 хувь) нь хөдөлгөөний, 20.4 мянга (19.3 хувь) нь сэтгэцийн, 7.3 мянга (6.9 хувь) нь хавсарсан, 32.2 мянга нь (30.5 хувь) нь бусад төрлийн бэрхшээлтэй байна⁹. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 2018 онд нийт 10 703 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1 730.2 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх оны мөн үеэс 3 042 (22.1 хувь) иргэнээр, зарцуулсан хөрөнгө 371.7 (17.7 хувь) сая төгрөгөөр буурсан байна. 2019 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 3 593 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд, 549.3 сая төгрөгийн ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг үзүүлсэн байна. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл, 17.0 хувь нь сонсголын дижитал аппарат, 10.5 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 8.7 хувь нь хөтөвч, суултуур (насан хүрэгсэд), 6.7 хувь нь нурууны даавуун хамгаалалт, 5.0 хувь нь тэргэнцэр (насан хүрэгчид), 4.2 хувь нь харааны шил, 3.4 хувь нь тохойн тулгууртай хос таяг, 2.9 хувь нь өвдгөвч, 2.1 хавар намрын гутал (захиалгаар хийх) авсан байна. Үйлчилгээнд хамрагдсан 6 хөгжлийн бэрхшээлтэй хүн тутмын нэг нь сонсголын дижитал аппарат, 10 хүн тутмын нэг нь нурууны ширэн бүс авсан байна.

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зарцуулсан хөрөнгийг үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл, 37.2 хувь нь сонсголын дижитал аппарат, 9.2 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 5.2 хувь нь тэргэнцэр (хүүхдийн), 4.7 хувь нь тэргэнцэр (насанд хүрэгсэд), 4.3 хувь нь хөтөвч, суултуур, 4.1 хувь нь дизи тоглуулагч, 3.3 насанд хүрэгсдийн стомын уут, 2.6 хувь нь хөлийн чиг бүхий аппарат, 2.5 хувь нь нурууны даавуун хамгаалалт, 2.3 хувь нь нурууны хуванцар хамгаалалт, 1.8 хувь нь ярьдаг даралтын аппаратанд зарцуулагдсан байна.

Хүснэгт 5. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, зарцуулсан хөрөнгө, төрөл, хувиар, 2018 он

Үйлчилгээний төрөл	Олгосон хүний тоо	Эзлэх хувь	Үйлчилгээний төрөл	Зарцуулсан дүн, сая төгрөг	Эзлэх хувь
Нийт	10703	100	Нийт	1730.2	100
Сонсголын дижитал аппарат	1816	17.0	Сонсголын дижитал аппарат	644.4	37.2
Нурууны ширэн хамгаалалт	1123	10.5	Нурууны ширэн хамгаалалт	158.3	9.2
Хөтөвч, суултуур (насанд хүрэгсэд)	935	8.7	Тэргэнцэр (хүүхэд)	90.0	5.2
Нурууны давуун хамгаалалт	715	6.7	Тэргэнцэр (насанд хүрэгсэд)	80.7	4.7
Тэргэнцэр (насанд хүрэгсэд)	538	5.0	Хөтөвч, суултуур (насанд хүрэгсэд)	74.4	4.3
Харааны шил	454	4.2	Дизи тоглуулагч	71.2	4.1
Тохойн тулгууртай таяг (хос)	369	3.4	Насанд хүрэгсдийн стомын уут	56.3	3.3
Өвдгөвч	310	2.9	Хөлийн чиг бүхий аппарат (урт)	45.3	2.6
Хавар намрын гутал(захиалга)	224	2.1	Нурууны давуун хамгаалалт	42.8	2.5
Гар таяг	211	2.0	Нурууны хуванцар хамгаалалт	40.2	2.3

⁹ ҮСХ, 1212.mn


Ярьдаг даралтын аппарат	204	1.9	Ярьдаг даралтын аппарат	30.6	1.8
Өвлийн гутал (захиалга)	200	1.9	Өвлийн гутал (захиалга)	29.97	1.7
Бусад	3604	33.7	Бусад	366.0	21.2

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

2019 оны хагас жилийн байдлаар нийт үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 13.7 сонсголын дижитал аппарат, 10.9 хувь нь хөтөвч, суултуур, 10.7 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 7.5 хувь нь нурууны даавуун хамгаалалт, 7.2 хувь нь тэргэнцэр (насанд хүрэгсэд), 4.3 хувь нь харааны шилний үйлчилгээг авсан байна. Зарцуулсан хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 31.4 хувийг сонсголын дижитал аппарат, 10.1 хувийг нурууны ширэн хамгаалалт, 7.1 хувийг тэргэнцэр, 5.7 хувийг хөтөвч, суултуур, 4.4 хувийг хүүхдийн тэргэнцэр, 4.2 хувийг насанд хүрэгсдийн стомын уут, 3.2 хувийг хөлийн чиг бүхий аппарат, 2.9 дизи тоглуулагчид зарцуулсан байна.

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 5 418 (50.6 хувь) нь орон нутгаас, 5 285 (49.4 хувь) нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 11.8 хувь нь Завхан, 10.3 хувь нь Хөвсгөл, 10.0 хувь нь Ховд, 7.3 хувь нь Архангай, 7.1 хувь нь Дундговь аймгуудаас хамрагдсан байна. Мөн тус үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зарцуулсан нийт хөрөнгийн 879.5 сая төгрөг (50.8 хувь) нь орон нутагт, 850.7 сая төгрөг (49.4 хувь) нь Улаанбаатар хотод зарцуулагдсан байна. Орон нутгийн зардлын 12.2 хувийг Хөвсгөл, 9.4 хувийг Хэнтий, 7.9 хувийг Дархан-Уул, 7.6 хувийг Завхан, 6.3 хувийг Архангай аймгуудад зарцуулсан байна.

Зураг 11. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аймгаар, 2018 он



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ-ын НХҮНМС-ийн тайлан

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамгийн их авсан 4 хэрэгслийг сонгож аймаг, дүүргээр тодруулж үзэхэд:

Сонсголын дижитал аппарат авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 61.6 хувь нь орон нутгаас, 38.4 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас сонсголын дижитал аппарат авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 16.1 хувь нь Хөвсгөл, 13.6 хувь Хэнтий, 11.7 хувь нь Дархан-Уул, 7.7 хувь нь Дорнод аймгаас хамрагдсан байна.


Нурууны ширэн хамгаалалт авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 57.9 хувь нь орон нутгаас, 42.1 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас нурууны ширэн

хамгаалалт авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 35.7 хувь нь Завхан, 16.0 хувь нь Архангай, 13.8 хувь нь Хөвсгөл аймгаас хамрагдсан байна.

Нурууны даавуун хамгаалалт авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 74.7 хувь нь орон нутгаас, 25.3 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас нурууны даавуун хамгаалалт авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 20.2 хувь нь Ховд, 17.2 хувь нь Завхан, 15.9 хувь нь Төв, 11.6 хувь нь Архангай аймгаас хамрагдсан байна.

Хөтөвч, суултуур авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 74.7 хувь нь орон нутгаас, 25.3 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Орон нутгаас хөтөвч, суултуур авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 16.7 хувь нь Хөвсгөл, 13.6 хувь нь Ховд, 8.5 хувь нь Завхан, 8.0 хувь нь Орхон аймгаас хамрагдсан байна.


Зураг 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн их хамрагдсан ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ, бүтэц, аймгаар, 2018 он



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ-ын НХҮНМС-ийн тайлан

2018 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд 5 285 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж, 850.7 сая зарцуулсан байна. Улаанбаатар хотоос тус үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний 23.3 хувь нь Сонгинохайрхан, 18.5 хувь нь Чингэлтэй, 15.7 хувь нь Баянзүрх, 13.1 хувь нь Баянгол, 12.4 хувь нь Хан-Уул, 10.5 хувь нь Сүхбаатар, 5.1 хувь нь Налайх, 0.8 хувь нь Багануур, 0.6 хувь нь Багахангай дүүргээс хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгөөр нь авч үзвэл, 25.3 хувийг Сонгинохайрхан, 16.1 хувийг Чингэлтэй, 15.6 хувийг Баянзүрх, 15.3 хувийг Баянгол, 12.8 хувийг Хан-Уул, 9.1 хувийг Сүхбаатар, 4.4 хувийг Налайх, 1.0 хувийг Багануур, 0.5 хувийг Багахангай дүүргүүдэд зарцуулсан байна.

Зураг 13. Улаанбаатар хотын ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зарцуулсан хөрөнгө, дүүрэг, эзлэх хувиар, 2018 он.



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ-ын НХҮНМС-ийн тайлан

Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үйлчилгээний төрлөөр нь харахад үйлчилгээ бүрт хүмүүс жигд хамрагдсан хандлагатай байна. Тус үйлчилгээнд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 13.2 хувь нь сонсголын дижитал аппарат, 9.6 хувь нь хөтөвч, суултуур, 8.9 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 5.4 хувь нь тэргэнцэр, 3.9 хувь нь тохойн тулгууртай хос таяг гэх мэт хэрэгслийг авсан байна. Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлтөд хамрагдсан 10 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрийн нэг нь сонсголын дижитал аппарат авсан байна.


Харин үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зарцуулсан хөрөнгийг үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл, 28.9 хувь нь сонсголын дижитал аппарат, 8.11 хувь нь хүүхдийн тэргэнцэр, 8.0 хувь нь нурууны ширэн хамгаалалт, 5.4 хувь нь тэргэнцэр, 4.8 хувь нь хөтөвч, суултуур гэх мэт үйлчилгээнд зарцуулагдсан байна.

Зураг 14. Улаанбаатар хотын ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлчилгээний төрөл, эзлэх хувиар, 2018 он.




Улаанбаатар хотоос ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдаж сонсголын аппарат авсан 5 хөгжлийн бэрхшээлтэй хүний нэг (23.2 хувь) нь Сонгинохайрхан дүүргээс, хөтөвч, суултуур авсан 4 хөгжлийн бэрхшээлтэй хүний нэг (25.5 хувь) Чингэлтэй дүүргээс, нурууны ширэн хамгаалалт авсан 3 хөгжлийн бэрхшээлтэй хүний нэг (31.5 хувь) нь Чингэлтэй дүүргээс, том хүний тэргэнцэр авсан 5 хөгжлийн бэрхшээлтэй хүний нэг нь (20.9 хувь) Чингэлтэй дүүргээс хамрагдсан байна.

Зураг 15. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн их хамрагдсан ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ, бүтэц, дүүргээр, 2018 он



Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ногдох дундаж зардлыг тооцож үзэхэд 161.7 мянган төгрөг байна. Нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд Дорноговь аймаг 266.1 мянган төгрөг, Хэнтий аймаг 259.3 мянган төгрөг, Дархан-Уул аймаг 255.0 мянган төгрөг, Говьсүмбэр аймаг 240.1 мянган төгрөгийг дунджаар зарцуулж байна.


Зураг 16. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ногдох дундаж зардал, аймгаар, 2018 он.



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ногдох дундаж зардал өндөртэй аймгуудыг авч үзвэл, Дорноговь 266.1 мянган төгрөг, Хэнтий аймаг 259.3 мянган төгрөг, Дархан-Уул аймаг 255.0 мянган төгрөг, Говьсүмбэр аймаг 240.1 мянган төгрөгийг нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зарцуулсан байна.

Зураг 17. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, нэг ахмад настанд ногдох зардал, мян.төг, аймгаар, 2018 он.



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ногдох дундаж зардлыг тооцож үзэхэд Улаанбаатар хотын дундаж 160.9 мянган төгрөг байна. Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүд нь хамгийн их хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан байна.

Зураг 18. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, нэг ахмад настанд ногдох зардал, мян.төг, дүүргээр, 2018 он.



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

4 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1 Үйлчилгээг хүртэгчид

Судалгаанд сонгогдсон аймаг, дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс ярилцлага хийж үйлчилгээний зохион байгуулалт, хэрэглэж буй ортопед болон тусгай хэрэгсэл, хүндрэл бэрхшээл, санал гомдлын талаар мэдээлэл цуглуулсан.

4.1.1 Үйлчилгээнд хамрагдсан иргэд

Судалгаанд хамрагдсан ахмад настны хувьд нурууны даавуун хамгаалалт, нурууны ширэн хамгаалалт, өвдгөвч, гар таяг, сонсголын дижитал аппаратыг хамгийн их авсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд сонсголын дижитал аппарат, тэргэнцэр, хараагүй хүний брайл хэрэгсэл, цаг, халууны шил, дизи тоглуулагч гэх мэт хэрэгслүүдийг хамгийн их авсан байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд алхуулагч, тэргэнцэр, зогсоогч, эмчилгээний бөмбөг, хөтөвч суултуурыг хамгийн их авсан байна.

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнээс дараах хэрэгслийг хамгийн их авж байна.

Ахмад настан	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
<ul style="list-style-type: none"> - Өвдгөвч (хос) - Нурууны ширэн болон даавуун бүс - Хөтөвч, суултуур - Гар таяг - Суга таяг - Алхуулагч - Тэргэнцэр - Сонсголын аппарат - Нүдний шил гэх мэт 	<ul style="list-style-type: none"> - Сонсголын аппарат - Тэргэнцэр - Нурууны ширэн болон даавуун бүс - Ярьдаг даралтны аппарат, цаг, халууны шил, дизи тоглуулагч - Хавар намрын гутал - Контакт линз - Харааны шил - Таяг гэх мэт 	<ul style="list-style-type: none"> - Алхуулагч - Тэргэнцэр - Зогсоогч - Хөтөвч, суултуур - Дасгалын бөмбөг - Сонсголын аппарат - Хөл, нурууны чиг - Нурууны бүс - Тавцантай ширээ гэх мэт

Мэдээлэл түгээлт

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдэд тухайн үйлчилгээний талаар мэдээлэл хангалтгүй байна. Иргэд тус үйлчилгээний талаарх мэдээллийг анх ам дамжсан яриа, эмнэлэгт үзүүлэх явцдаа олж авдаг байна. Тухайн олж авсан мэдээлэл дээрээ үндэслэн харьяа нийгмийн халамжийн байгууллагад хандаж, бүрдүүлэх шаардлагатай материал, үйлчилгээний талаар мэдээллийг авдаг. Мөн орон нутагт тусгай хэрэгсэл нийлүүлэх зөвшөөрөл авсан байгууллагууд орон нутгийн нээлттэй хаалганы өдөрт очиж танилцуулга хийж, байгууллагаа сурталчилаад ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээнд хамрагдах боломжтой иргэдийг хамруулдаг байна.

Бусад үйлчилгээнд хамрагдсан байдал

Судалгаанд хамрагдсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь нийгмийн халамжийн 2-3 үйлчилгээнд хамрагдсан байна. Ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээнд хамрагдсан иргэд тус үйлчилгээнээс гадна халамжийн тэтгэвэр, халамжийн асаргааны тэтгэмж, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, хүүхдийн мөнгө, хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдсан байна.

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнээс гадна дараах үйлчилгээнд иргэд хамрагдаж байна.

Ахмад настан	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
<ul style="list-style-type: none"> - Асаргааны мөнгөн тэтгэмж - Насны хишиг - Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж - Хүнс тэжээлийн дэмжлэг 	<ul style="list-style-type: none"> - Асаргааны мөнгөн тэтгэмж - Халамжийн тэтгэвэр, тэтгэмж - Хүнс тэжээлийн дэмжлэг - Хүүхдийн мөнгө 	<ul style="list-style-type: none"> - Асаргааны мөнгөн тэтгэмж - Халамжийн тэтгэвэр, тэтгэмж - Хүүхдийн мөнгө

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хувьд 2014 оны 6 сараас 2019 оны 8 сарын хооронд үйлчилгээнд хамрагдсан байна. Тус үйлчилгээнд хамрагдахдаа иргэд ортопед болон тусгай хэрэгсэл нийлүүлэгч, халамжийн байгууллагад хүсэлтээ тавиад авах, эсвэл өөрсдийн мөнгөөрөө худалдаж аваад тухайн байгууллагаас төлбөр төлсөн баримт аваад үнийн хөнгөлөлтөд хамрагдах тохиолдлууд гарч байна. Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ихэнхдээ нэхэмжлэхээр авсан байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгслийг иргэд өөрсдөө эхэлж худалдаж аваад дараа нь хөнгөлөлт эдлэх тохиолдол ихээхэн гарсан байна.

Өөрөө худалдаж авсан ортопед болон тусгай хэрэгсэл

- Сонсголын дижитал аппарат
- Тэргэнцэр
- Суултуур
- Хүүхдийн зогсоогч
- Хүүхдийн хөл, гарын чиг
- Хүүхдийн алхуулагч
- Нурууны ширэн хамгаалалт гэх хэрэгслийг авсан байна.

Өөрөө ортопед болон тусгай хэрэгсэл худалдаж авсан иргэдээс тусгай хэрэгслийнх нь талаар асууж тодруулсан. Нийгмийн халамжийн хөнгөлөлтөөр тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагуудын тусгай хэрэгслийн чанар, хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байдлаас болж бусад өөр байгууллагаас чанар, хэрэгцээг хангасан тусгай хэрэгсэл авсан байна. Мөн орон нутгийн иргэдийн хувьд тухайн орон нутагт тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагад нь тухайн иргэний хэрэгцээ, шаардлагад нийцсэн тусгай хэрэгсэл байхгүй тохиолдолд бусад байгууллагаас худалдаж авах тохиолдол нилээдгүй гарсан.

*Нийгмийн халамжаас тараадаг 350.0 мянган төгрөгийн сонсголын аппарат нь үнэхээр хэрэглэхэд хүнд. Өмнө нь би авч зүүж үзсэн. Хэдхэн хоноод л шуугиад эхэлдэг. Мөн ус, доргионы хамгаалалтгүй, дижитал биш аппаратууд тараадаг. Ийм чанаргүй биед тохиромжгүй аппаратыг л хүмүүс хэрэглэж байна.*¹⁰

*Нийгмийн халамжаас сонсголын аппаратыг бид Улаанбаатар хотод чих, хамар, хоолойн эмнэлгээс авсан. Манай нутагт сонсголын аппарат нийлүүлдэг байгууллага байхгүй болохоор хотоос авсан. Чанар муутай аппарат авахын тулд бөөн зардал болж л явсан.*¹¹

Онлайн захиалгаар хүүхдийн хөлний чиг худалдаж авсан боловч чиг нь таарахгүй байгаа, хөнгөлөлтөө ч эдэлж чадаагүй. Уг нь манай орон нутагт чиг нийлүүлдэг

¹⁰ Чингэлтэй дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас

¹¹ Завхан аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

*байгууллага байсан бол ийм асуудал гарахгүй байсан. Миний ч бас мэдээлэлгүйгээс болсон байх.*¹²

Өөрөө ортопед болон тусгай хэрэгсэл худалдаж авсан иргэдийн хувьд тусгай хэрэгслийг чанартай, биед эвтэйхэн, удаан хэрэглэдэг гэж хүмүүс хэлж байсан. Ялангуяа тэргэнцэр, сонсголын дижитал аппаратны хувьд хэрэглэх хугацаа, хамгаалалт нь нийгмийн халамжаас тараадаг тусгай хэрэгслээс 2 дахин илүү гэж иргэд тодорхойлж байна. Харин нийгмийн халамжийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээгээр авсан сонсголын аппарат нь эдэлгээ муу, биед тохиромжгүй, амархан шуугиж, эвдэрдэг гэж тодорхойлсон байна.

*Чанарын хувьд их ялгаатай. Сонсголын аппаратыг нэг мөсөн сайныг нь авахгүй бол халамжийн аппарат амархан эвдэрдэг.*¹³

*ОУБ-аас тусламжаар өгсөн тэргэнцэр нь маш сайн байгаа. Бараг 6 жил хэрэглэж байхад ямар ч эвдрэл гэмтэлгүй байна. Гэтэл нийгмийн халамжаас тэргэнцэр авсан, чанар муу байна. Манай хүүхдийн сая авсан тэргэнцэр биед нь таарахгүй, тохиромжгүй, хамгаалалтын бүс нь холгох, дугуй нь хурдан хагарах гэх мэт асуудлууд ихээхэн гардаг.*¹⁴

*Бүтээгдэхүүнүүд нь чанаргүй хэцүү л юмнууд байгаа юм. Бид нар ч үнээгүй өгч байгаа болохоор чимээгүй авдаг.*¹⁵

Өөрөө ортопед болон тусгай хэрэгсэл худалдаж авсан иргэдийн хувьд тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагаас нэхэмжлэхээ аваад, нийгмийн халамжийн байгууллагад материалаа бүрдүүлж өгөөд, үнийн хөнгөлөлтөд хамрагдах хүсэлтээ өгсөн боловч хагас жилээс дээш хугацаагаар хөнгөлөлтийг өгөөгүй тохиолдол нилээдгүй гарсан байна.

Харин нийгмийн халамжид хүсэлтээ тавиад авсан орон нутгийн иргэдийн хувьд дунджаар 24 хоногийн дотор, нийслэлийн иргэдийн хувьд 5 хоногийн дотор тусгай хэрэгслээ авч байна.

Нийгмийн халамжаас авсан иргэд	Өөрөө худалдаж авсан иргэд
<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн иргэдийн хувьд дунджаар 24 хоногийн дотор - Хотын иргэдийн хувьд 5 хоногийн дотор тусгай хэрэгслээ авдаг байна. 	<ul style="list-style-type: none"> - Өөрөө ортопед болон тусгай хэрэгсэл худалдаж авсан иргэдийн хувьд тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагаас нэхэмжлэхээ аваад халамжийн байгууллагад өгсөн боловч үнийн хөнгөлөлтөө хагас жилийн дараа авсан тохиолдолууд гарсан байна.

Судалгаанд хамрагдсан иргэдээс мөн цаашид ямар ортопед болон тусгай хэрэгсэл хэрэгцээ, шаардлагатай байгаа эсэхийг нь тодруулахад сайн чанартай тэргэнцэр, хөтөвч, суултуур, алхуулагч, сонсголын дижитал аппарат гэх мэт хэрэгсэл авах сонирхолтой байна. Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд согог засах гутал, нумтай улавч авах сонирхолтой байгаа хэдий ч Улаанбаатар хотод очиж захиалга өгдөг тул очиж авч чадахгүй байна. Орон нутгийн иргэд тухайн аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэх эрх бүхий байгууллагад байхгүй хэрэгслийг захиалж авдаг болох хүсэлтэй байна. Байгууллагуудын хувьд байхгүй хэрэгслийг захиалдаг ч зарим тохиолдолд сонсголын аппарат, согог засах гутал, чиг, бусад хэрэгслийг иргэд заавал Улаанбаатар хотод очиж хийлгэх шаардлагатай болдог бөгөөд энэ нь чирэгдэл ихтэй байдаг. Мөн согог засах гутал, нумтай гутлыг үйлдвэрлэдэг байгууллагууд маш цөөхөн байдаг, гутлын хэмжээгээ өгөхийн тулд олон хоног хүлээх

¹² Өвөрхангай аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБХ-тэй хийсэн ярилцлагаас
¹³ Өвөрхангай аймгаас үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас
¹⁴ Завхан аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБХ-тэй хийсэн ярилцлагаас
¹⁵ Завхан аймгаас үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас

асуудал үүсдэг байна. Сонсголын дижитал аппаратыг орон нутагт нийлүүлдэг байгууллага ховор, зарим нь чанаргүй аналог аппарат нийлүүлдэг учир иргэд авах сонирхолгүй байна. Тухайн орон нутгийн халамжийн байгууллагын зүгээс заавал авах ёстой, эсвэл тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамруулахгүй гэсэн тохиолдол гарсан байна.

*Хөлийн чиг, нурууны хамгаалалт, цооролтоос сэргийлсэн зөөлөвч, алхуулагч хэрэгтэй байгаа.*¹⁶

*Сайн чанартай сонсголын аппараттай болчихвол 5, 10 жилдээ бол ахиж аппарат гэхгүй байх. Одоо энэ өгч байгаа сонсголын аппарат 3 жил хүрэлгүй эвдэрдэг.*¹⁷

*Чанартай, өөрөө явдаг тэргэнцэр байвал хэрэгтэй байна. Алхуулагч бас хэрэгтэй байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй гэхээрээ нийгмээс тусгаарлагдаж заавал нэг харгалзагчтай баймааргүй байна. Өөрөө явдаг тэргэнцэртэй болчихвол ядаж л дэлгүүр хоршоо, ус түлээндээ явчих байх.*¹⁸

Хэрэгцээ, шаардлагатай байгаа ортопед болон тусгай хэрэгсэл

Ахмад настан	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
<ul style="list-style-type: none"> - Тэргэнцэр - Сонсголын аппарат - Нүдний шил - Суултуур - Алхуулагч 	<ul style="list-style-type: none"> - Тэргэнцэр - Мэдрэгчтэй таяг, ярьдаг даралтны аппарат, радио - Сонсголын аппарат - Хөл нурууны чиг - Суултуур - Алхуулагч - Нумтай улавч, гутал - Памперс 	<ul style="list-style-type: none"> - Тэргэнцэр - Зогсоогч - Хөл, нурууны чиг - Согог засах гутал

Үйлчилгээнд хамрагдаагүй шалтгаан

Ортопед, тусгай хэрэгсэл авч чадахгүй байгаа шалтгааныг тодруулахад тухайн газрын ортопед болон тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагад хүссэн тусгай хэрэгсэл нь байхгүй байх, хэмжээ нь таарахгүй /том эсвэл жижиг/ байх, чанар муутай бүтээгдэхүүн байх, өмнө нь хамрагдаж байсан болохоор хугацаа нь болоогүй гэсэн шалтгааныг ихэнх нь дурдсан байна.

Үйлчилгээний ач холбогдол

Мөн судалгаанд хамрагдсан иргэдээс тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт эдлэх нь хэр ач холбогдолтой талаар асууж тодруулахад судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь маш их ач холбогдолтой гэж онцолсон.

*Хэрэгтэй хүндээ маш их хэрэгтэй үйлчилгээ. Нийгмийн халамжийн үйлчилгээнүүдээс хамгийн сайн хүндээ хүрдэг үйлчилгээ гэж би бодож байна.*¹⁹

*Маш их ач холбогдолтой. Хэрвээ энэ суултуур, таяагүй болчихвол явж чадахгүй, бие засаж чадахгүй. Маш чухал хэрэгцээтэй үйлчилгээ. Гэхдээ сайжруулах шаардлага байгаа.*²⁰

¹⁶ Завхан аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБХ-тэй хийсэн ярилцлагаас

¹⁷ Чингэлтэй дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас

¹⁸ Завхан аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

¹⁹ Чингэлтэй үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас

²⁰ Завхан аймгаас үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас

*Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс маш их зардалтай байдаг. Улсаас ингэж хөнгөлөлт эдлүүлж байгаа нь үнэхээр ач холбогдолтой үйлчилгээ.*²¹

Үйлчилгээнд хамрагдах хугацаа

Иргэд ортопед болон тусгай хэрэгслийн дахин олгох хугацааг тусгай хэрэгсэл бүр дээр өөр байх хэрэгтэй гэж үзэж байна. Тухайлбал ахмад настнуудын хувьд удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний хугацааг нь хэвээр үлдээх, бусад бүтээгдэхүүний хугацааг нь багасгаж 3 жил болгох шаардлагатай гэж үзэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд тусгай хэрэгсэл бүрээр хугацааг нь өөр болгох хэрэгтэй гэж үзсэн. Байнга хэрэглэгдэж болохуйц чанар сайтай тэргэнцэр, сонсголын аппаратыг бол 5 жил хэрэглэнэ гэж үзсэн. Харааны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд мэдрэгчтэй таягыг жил болгон өгөх шаардлагатай байгааг онцгойлон хэлсэн. Харааны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдрэгчтэй цагаан таягаа хөшиж хугалах, машинд дайруулах, хүнд гишгүүлэх гээд асуудлууд өдөр болгон тулгардаг тул амархан эвдэрдэг учир хугацаа нь богино байх шаардлагатай гэж үзсэн.

*Таягны хувьд хугацааг нь богиносгож, 1 жил болгох хэрэгтэй. Бидэнд таягаа хөшиж хугалах, гарцаар гарахдаа машин дайруулж хугалах, хүн гишгэж хугалах гэх мэт асуудал зөндөө гардаг.*²²

*Тусгай хэрэгслээсээ л шалтгаалаад өөр байх. Зарим тусгай хэрэгслүүд нь 3 жилээ дааж байна, зарим нь жил болохгүй эвдрээд байх жишээтэй байна.*²³

*Амархан эвдэрдэг болохоор 3 жил хангалтгүй байна. Эсвэл сайн чанартай юм өгвөл 3 жил хангалттай л байх.*²⁴

*3 жилийн хугацаа бол хангалттай хугацаа. Харин гутлын хувьд үнэхээр хэцүү. Хүүхэд том болох тусам гутал нь багадана. Тэгэхээр тухай бүрт нь сольж байвал зүгээр байна.*²⁵

Үйлчилгээнд хамрагдаж буй иргэнд тулгарч буй хүндрэл бэрхшээл

Судалгаанд хамрагдсан ихэнх иргэдийн хувьд уг үйлчилгээтэй холбоотой хүндрэл бэрхшээл гараагүй байна.

Ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллага нь биед тохиромжгүй, амархан эвдэрч мууддаг бүтээгдэхүүн нийлүүлж байгаа нь, эмнэлэг магадлалын комиссын хурал сард нэг удаа болдог нь хүндрэлтэй байдаг байна. Харин Улаанбаатар хотоос хамрагдсан иргэдийн хувьд тусгай хэрэгсэл нэхэмжлэхээр өгөхгүй байгааг ихээхэн шүүмжилж, хүндрэл учруулж байгааг хэлж байсан. Мөн Налайх дүүрэгт тусгай хэрэгсэл нийлүүлдэг байгууллага байдаггүй тул иргэдийн хувьд хот явах нь хүндрэлтэй байгааг онцолж байсан.

*Одоо л их хүндрэлтэй болж байна. Яагаад заавал хот орж тухайн бүтээгдэхүүнийг авна гэж вэ? зардал нь хэд болох уу хэд очиж буцах уу гээд асуудал их байна.*²⁶

*Бүтээгдэхүүнүүд нь чанар муу байдаг. Биед тохиромжгүй таарахгүй байхад ав гээд тулгадаг. Бид нар ч үнэгүй өгч байгаа болохоор чимээгүй авч байна.*²⁷

*Маш их явсан, эмч нарийг их хүлээсэн. Группын хурлыг их хүлээсэн. Их л удаж байж хурлаа хийгээд шийдвэр гаргаж өгсөн. Мөн тухайн байгууллагын бүтээгдэхүүн нь дуусчихсан байсан.*²⁸

²¹ Налайх дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

²² Чингэлтэй дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

²³ Завхан аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

²⁴ Налайх дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

²⁵ Налайх дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

²⁶ Налайх дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас

²⁷ Чингэлтэй дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас

²⁸ Өвөрхангай аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

*Хүндрэл бэрхшээл гарч байна. Хот руу очиж авах үнэхээр хэцүү байна. Бас өөрсдөө мөнгөө гаргаад стомын уут авна гэдэг чинь маш их зардалтай. Тэтгэврийн мөнгө гээд сард 200 мянга төгрөг авдаг хүмүүс 720 мянган төгрөгийг нэг өдөр шууд гаргаад стомын уут авна гэхээр хэцүү шүү дээ.*²⁹

Ортопед болон тусгай хэрэгслийн хэрэглэх явцад ямар нэгэн эвдрэл гэмтэл, хэрэглэх явцад хүндрэлтэй байх, биед тохиромжгүй байх зэрэг асуудал тулгарч байгаа эсэхийг асууж тодруулсан. Үйлчилгээ хүртэгчид дараах хүндрэл, асуудлуудыг тавьсан.

- Суултуур нь босоод суухад эвхэгдэх;
- Сонсголын дижитал аппаратын хувьд ус, доргионы хамгаалалтгүй учир амархан эвдрэх, шуугих;
- Нурууны ширэн хамгаалалтын хувьд томдсон, багадсан хэмжээтэйг өгөх;
- Даавуун хамгаалалтын хувьд амархан сэмрэх, урагдах;
- Тэргэнцэрийн хувьд даац муутай, дугуй нь хагардаг, нөхөж болдоггүй дугуйтай байгаа нь;
- Хүүхдийн тэргэнцэрийн хамгаалалтын бүс нь шигдэж орох, тасрах асуудлууд ихээхэн гарсан байна.

*Хэрэглээд жил хүрэхгүй л эвдэрчихдэг. Дугуйнаас нь авахуулаад үнэхээр муу. Чанар муутай болохоор сургуульд хүүхдээ зөөхгүй байгаа. Уначих юм болов уу, хагарчих юм болов уу гэж бодоод ерөөсөө ашиглахгүй байгаа. Нийгмийн халамжаас өгдөг гэхээрээ л чанар муутай байж болохгүй биз дээ. Би хүүхдээ 2 удаа унагасан болохоор л хэрэглэхээ больсон. Бас хамгаалалтын бүс нь ч биеийг нь холгох, шигдэх асуудлууд гарсан болохоор огт хэрэглэхгүй байгаа.*³⁰

*Эвдрэл гарах нь асуудал биш ээ. Тухайн хүнээс шалтгаална. Миний сая авсан тэргэнцэр бол миний биед үнэхээр тохиромжгүй байгаа. Хоёр тийшээ уначих гээд хэцүү байдаг. Даац муутай, хөгжлийн бэрхшээлтэй хөдөлгөөнгүй байдаг хүмүүс чинь илүүдэл жинтэй хүмүүс байдаг. Бүс нь энд тэнд шигдэж орчих гээд хэцүүхэн байдаг.*³¹

*Суултуур дээр сууж байгаад босохоор эвхэгдээд байгаа. Үүнээс болоод унах асуудал зөндөө байна.*³²

*Сонсголын аппаратны хувьд шуугиад юм сайн сонсогдохгүй байгаа. Нэг мөсөн сайн аппарат авсан дээр юм байна лээ. Тухайн аппаратыг зүүхээс дургүйцээд байгаа. Сургууль амарснаас хойш ерөөсөө зүүгээгүй хуучин аппаратаа зүүж байгаа. Гуурс нь болохгүй байгаа юм байна гэж бодоод солиулсан чинь чихийг нь үрээд байгаа юм шиг байна.*³³

Үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагын талаар

Тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагын талаар иргэд ихэнхдээ эмч, нийгмийн халамжийн ажилтан, ам дамжсан ярианаас мэдээлэл авсан байна. Иргэдийн хувьд тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагуудыг нээлттэй хаалганы өдөрлөг, олон нийтийг хамарсан үйл ажиллагаан дээр ирж танилцуулгаа хийж, үйлчилгээг үзүүлэхийг хүсч байна. Мөн орон нутагт нийлүүлэгч байгууллагуудын тусгай хэрэгслийг сонголттой байлгах, хүртээмжтэй байлгах, олдцтой байлгах тал дээр анхаарах хэрэгтэйг хэлсэн. Мөн тухайн орон нутагт нь сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллага байхгүй нь үйлчилгээг хүртэж чадахгүй байх шалтгаан болж байна гэж тодорхойлсон. Харин Улаанбаатар хотоос хамрагдсан иргэдийн

²⁹ Налайх дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

³⁰ Өвөрхангай аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБХ-тэй хийсэн ярилцлагаас

³¹ Завхан аймгаас үйлчилгээнд хамрагдсан ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

³² Өвөрхангай аймгаас үйлчилгээнд хамрагдсан ахмад настантай хийсэн ярилцлагаас

³³ Чингэлтэй дүүргээс үйлчилгээнд хамрагдсан ХБХ-тэй хийсэн ярилцлагаас

хувьд тусгай хэрэгслийг сонголттой, чанартай болгох, нэхэмжлэхээр олгох тал дээр анхаарах хэрэгтэй гэсэн.

Үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагууд нь баталгааны хугацааны талаар хүмүүст мэдээлэл огт өгдөггүй байна.

Үйлчилгээ хэрэгжүүлэгч байгууллагын талаар анхаарах зүйлс

Орон нутгаас хамрагдсан иргэд	Нийслэлээс хамрагдсан иргэд
<ul style="list-style-type: none"> - Олон сонголттой болгох - Хүртээмжтэй болгох - Чанартай болгох - Олдоцтой болгох - Орон нутагт нь нийлүүлэгч байгууллага байх шаардлагатай байгаа - Хэрэглэх заавар танилцуулах - Баталгаат хугацаанд засвар үйлчилгээг үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Олон сонголттой болгох - Чанартай болгох - Нэхэмжлэхээр олгох - Хэрэглэх заавар танилцуулах - Баталгаат хугацаанд засвар үйлчилгээг үзүүлэх - Тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагын талаар мэдээлэл сайн түгээх

Үйлчилгээг сайжруулах санал

- ✓ Ортопед болон тусгай хэрэгсэл борлуулдаг төрөлжсөн дэлгүүр, худалдааны төв, мэдээллийн цахим хуудастай болох;
- ✓ Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдах хугацааг удаан эдэлгээтэй, богино хугацааны тусгай хэрэгсэл гэж хэрэгсэл бүр дээр хугацааг өөрчлөх;
- ✓ Шаардлагатай зарим тусгай хэрэгслийн үнийн дүнг нэмэгдүүлэх, зарим бүтээгдэхүүнийг хасах;
- ✓ Тусгай хэрэгсэл нийлүүлэгч, нийгмийн халамжийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;
- ✓ Нийлүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүний чанарт анхаарах;
- ✓ Нийлүүлэгч байгууллагуудад тэгш өрсөлдөх боломжийг олгох;

4.1.2 Үйлчилгээнд хамрагдаагүй иргэд

Судалгаанд сонгогдсон аймаг дүүргээс үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй боловч хамрагдаагүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс ярилцлага хийж нийгмийн халамжаас авч буй үйлчилгээ, ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдаагүй шалтгаан, үйлчилгээ болон нийлүүлэгч байгууллагын талаар хэр мэдээлэлтэй байгаа талаар асууж тодруулсан юм.

Орон нутгийн иргэд тухайн орон нутагт нь үйлчилгээ үзүүлэгч байгууллага байхгүй байх, байгууллагад нь тухайн иргэнд шаардлагатай тусгай хэрэгсэл байхгүй, тусгай хэрэгсэл худалдаж авах мөнгө санхүүгийн боломжгүй байх, мэдээлэл дутмаг байдал зэргээс шалтгаалан ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй байна.

Намайг эмч нарын зөвлөгөөнөөс хагалгаанд орохгүй бол өндөр нам болгодог тусгай гутал өмсөх шаардлагатай гэж оношилсон. Нийгмийн халамжийн мэргэжилтнээс асуухад манай аймагт ийм бүтээгдэхүүн байдаггүй тул асууж лавлаж өгнө гэсэн. Хаана ямар байгууллага хийдэг талаар би ямарч мэдээлэлгүй байгаа. Эмч нар хэлэхдээ би хоёр тийшээ хазайж явдаг болохоор тэнцвэржүүлэх шаардлагатай гэсэн. Манай аймагт ийм тусгай гутал нийлүүлдэг байгууллага байхгүй тул авч

чадахгүй байна. Улаанбаатар хот орж үзээгүй болохоор бас л хүн дагуулж явах болно тэгэхээр зардал их гарна.³⁴

Би 2017 онд хараагүй болсон. Хараагүй хүний тусгай хэрэгсэл хэрэгтэй байгаа. Ярьдаг даралтны аппарат, халууны шил байдаг гэж сонссон боловч авч чадахгүй байна. Нийгмийн халамжаас асуухаар манай орон нутагт тийм юм байхгүй гээд тоодоггүй.³⁵

Нийгмийн халамжийн мэргэжилтнээс мэдээлэл аваад суултуур авах хүсэлтээ 6 сард өгсөн боловч одоо болтол авч чадаагүй. Нэг очиход нийгмийн халамжийн мэргэжилтэн нь амарсан байсан. Одоо болохоор нэхэмжлэхээр өгөхгүй бэлэн мөнгөөр ав гээд байгаа.³⁶

Өмнө нь сонсож байгаагүй. Саяхан нийгмийн халамжийн мэргэжилтнээс мэдээлэл аваад хүүдээ гутал хийлгэх гэж байгаа. СЗСҮТ дээр очиж гутал хийлгэж болно гэсэн. СЗСҮТ-ийн эмч нь үзээд гутал хийлгэх боломжтой гэсэн.³⁷

Нийгмийн халамжийн мэргэжилтнээс асууж үзээгүй ээ. Одоо тэргэнцэр суултуур хэрэгтэй байна. Мэдээлэлгүйгээс болоод л авч чадахгүй байна.³⁸

Орон нутгийн иргэд нийгмийн халамжаас тусгай хэрэгсэл өгдөг талаар мэдээлэлгүй тул суултуур, таяг, согог засах гутал, тэргэнцэр гэх мэт тусгай хэрэгслүүдийг хувийн байгууллагаас худалдаж авсан байна. Мөн эмнэлэгт эмчлүүлж байхдаа тэргэнцэр, суултуур, алхуулагч, таягыг авсан тохиолдол гарсан байна. Хэрвээ мэдээлэлтэй байсан бол төлбөр төлсөн баримт болон бусад холбогдох баримтыг бүрдүүлээд хамрагдах боломжтой байсан гэж хариулсан.

Үйлчилгээнд хамрагдаагүй иргэд өөрсдөө худалдаж авсан хэрэгслүүд

Орон нутгийн иргэд	Нийслэлийн иргэд
<ul style="list-style-type: none">- Тэргэнцэр- Хөтөвч, суултуур- Нурууны хамгаалалт- Хүүхдийн зогсоогч- Таяг- Хүүхдийн тэргэнцэр- Хүүхдийн алхуулагч	<ul style="list-style-type: none">- Тэргэнцэр- Хөтөвч, суултуур- Хүүхдийн тэргэнцэр- Хүүхдийн алхуулагч- Стомын уут

Тэргэнцэрээ 250 мянгаар худалдаж авсан. Гэмтлийн эмнэлэгт хэвтэж байхдаа эмнэлгээс худалдаж авсан. Байнга суудаггүй хааяа гарахдаа хэрэглэдэг. Байнга хэрэглэхгүй болохоор эвдрэх асуудал гараагүй. Суултуурыг нь эмийн сангаас худалдаж авсан. Тухай бүрт нь баримт авсан гэхдээ нийгмийн халамжаас буцаан олгодог талаар мэдээлэлгүй байсан.³⁹

Турк улсаас 60000 төгрөгөөр таяг авсан. Нарантуул захаас 82000 суултуур, 45000 бүс авсан. Таяг 3 жил хэрэглээд хугарсан. Суултуур нь 2 жил болж байгаа. Бүс 6 сар болж байна. Судалж үзээгүй. Нийгмийн халамжаас үнээгүй өгдөг гэдгийг саяхан мэдсэн. Одоо таяг авах хэрэгтэй байгаа.⁴⁰

³⁴ Завхан аймгийн ХБИ-тэй хийсэн ярилцлагаас

³⁵ Өвөрхангай аймгийн ахмад настантай хийсэн ярилцлагаас

³⁶ Налайх дүүргийн ахмад настантай хийсэн ярилцлагаас

³⁷ Чингэлтэй дүүргийн ХБХ-тэй хийсэн ярилцлагаас

³⁸ Өвөрхангай аймгийн ахмад настантай хийсэн ярилцлагаас

³⁹ Чингэлтэй дүүргийн ахмад настантай хийсэн ярилцлагаас

⁴⁰ Өвөрхангай аймгийн ахмад настантай хийсэн ярилцлагаас

Судалгаанд хамрагдсан иргэдээс өөртөө хэрэгтэй ортопед болон тусгай хэрэгслийг нийгмийн халамжийн хөнгөлөлт эдлэхгүйгээр худалдан авах боломжтой эсэхийг нь тодруулж асуухад ихэнх иргэдийн хувьд өөрсдөө худалдаж авах боломжгүй гэж хариулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрөө нэг дор мөнгө гаргаад тусгай хэрэгсэл худалдаж авах үнэхээр хэцүү байдаг талаар онцолж байсан.

*Зөрүү мөнгийг нь өгч чадахгүй болохоор хамрагдаж чадахгүй байна. Халамжийн тэтгэвэрийн мөнгө хүрэлцэхгүй байхад өөрөөсөө мөнгө гаргаад тусгай хэрэгсэл худалдаж авна гэдэг бол худлаа.*⁴¹

*Эмч зөвлөгөө өгөөд нийгмийн халамжаас сонсголын аппарат авах гэж хөөцөлдөж байгаа. Миний чих маш их өвддөг. Хагалгаанд орох гэхээр уушиг идээтэй, хагалгаагаа дийлэхгүй гэдэг. Тийм болохоор зайлшгүй сонсголын аппарат хэрэг болж байгаа. Хувийн компани аймгийн нэгдсэн эмнэлэг дээр ирээд эмчилгээний сонсголын аппарат тарааж байсан. Тухайн аппаратыг авах гээд очтол тал мөнгийг нь төлчихвөл авч болно гэсэн. Энэ талаар нийгмийн халамжийн мэргэжилтнээс асуухад тал мөнгөө төлөөд авч болно гэсэн. Миний чихэнд тохирсон аппарат нь 900 мянган төгрөг гээд байгаа юм. Мөнгийг нь гаргаж чадахгүй болохоор нийгмийн халамжийн үйлчилгээндээ хамрагдаж чадахгүй байна.*⁴²

4.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын төлөөлөл

Судалгааны мэдээлэл цуглуулалтын явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын төлөөлөлтэй уулзаж гишүүдийн хэрэглэдэг ортопед, тусгай хэрэгсэлтэй танилцаж нийгмийн халамжийн сангаас олгож буй ортопед, тусгай хэрэгслийн ялгаа, үнийн талаар мэдээлэл авахыг зорьсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ дээр тогтмол ажилладаг иргэдийн дунд тэргэнцэр ашиглагдаг нуруу нугасны гэмтэлтэй, саажилттай иргэд олон байсан. Үүнээс нийгмийн халамжийн сангийн үнийн хөнгөлөлтөөр ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагаас тэргэнцэр авсан иргэд цөөн байна.

Ихэнх нь тусламжын шугамаар орж ирсэн болон өөрөө бусад улс орнуудаас авсан тэргэнцэр хэрэглэдэг бөгөөд нийгмийн халамжийн сангаас олгож буй ортопед болон тусгай хэрэгсэл таарч тохирдоггүй, тэргэнцэр нь ашиглахад тохиромжгүй гэж хариулсан.

*Миний сууж байгаа тэргэнцэрийг Солонгос найз миний бэрхшээлийн онцлогт тохируулж хийж өгсөн. Тэргэнцэр ямар байх нь миний бие эрхтэн, сэтгэл зүйд маш их нөлөө үзүүлдэг. Би өглөө ажилдаа 10 цагт ирээд орой 20 цагт гэртээ харьдаг. Өдөржин суухад би ямарч ачаалал авдаггүй. Тиймээс тэргэнцэрийн тохиромжтой байдал нэн чухал, би нийгмийн халамжаас олгож байгаа тэргэнцэр дээр суувал өдрийн хагас ч сууж чадахгүй. Тиймээс тогтолцоог өөрчлөх хэрэгтэй. Одоо манай байгууллагад ажиллаж байгаа 16 иргэний 9 нь хөгжлийн бэрхшээлтэй, тэдний 6 нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй.*⁴³

Тэргэнцэртэй иргэд буюу нуруу нугасны гэмтэлтэй, тулгуур эрхтэний бэрхшээлтэй тогтмол тэргэнцэр дээр суудаг иргэдийн хувьд зориулалтын бус тэргэнцэр хэрэглэснээс, зөв суугаагүйгээс болж цооролт үүсэх, бөөрний дутагдалд орох тохиолдол их байдаг ба энэ нь цаашлаад үхэлд хүргэх аюултай. Нуруу нугасны гэмтэлтэй, тулгуур эрхтэний бэрхшээлтэй иргэдийн хувьд тэргэнцэрийг зайлшгүй өдөр тутамдаа хэрэглэдэг ба нийгмийн халамжийн сангаас олгодог бусад ортопед болон тусгай хэрэгслийн хувьд бараг шаардлагатай хэрэгсэл байдаггүй. Тиймээс тэргэнцэр нь хүний биед тохирсон бэрхшээлийн

⁴¹ Завхан аймгийн ахмад настантай хийсэн ярилцлагаас

⁴² Өвөрхангай аймгийн ахмад настантай хийсэн ярилцлагаас

⁴³ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын гишүүнтэй хийсэн ярилцлагаас

онцлогт нийцсэн байх шаардлагатай гэсэн саналыг өгсөн. Тэргэнцэрийг дараах байдлаар гурав ангилж үздэг.

- Эмнэлгийн зориулалттай
- Хэрэглээний
- Спортын

Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа насанд хүрэгсдийн тэргэнцэр нь жишиг үнээр 150.0 төгрөг бөгөөд нийлүүлэгч байгууллагууд жишиг үнэд тааруулж эмнэлгийн зориулалттай тэргэнцэрийг оруулж ирдэг. Тиймээс тулгуур эрхтэний бэрхшээлтэй нуруу нугасны гэмтэлтэй иргэд тогтмол эмнэлгийн зориулалттай тэргэнцэр хэрэглэх нь биед тохирдоггүй, амархан эвдрэх, цооролт холголт үүсгэх эрсдэлтэй байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоод Япон, Солонгос, Герман, Канад болон бусад улс орнуудын тусламжийн байгууллагуудаас хуучин тэргэнцэрийг оруулж ирэх, тэргэнцэр засварын төв байгуулах, тэргэнцэр засварчинг бэлтгэх чиглэлээр хамтарч ажилладаг.

Эхэндээ юу ч мэдэхгүй үед улсаас олгодог буюу нийгмийн халамжаас олгодог тэргэнцэрийг хэрэглэдэг. Би эхний 10 жил тэр том тэргэнцэр дээр суусан. Манай улс ихэнхдээ Хятадаас оруулж ирдэг. Сүүлийн үед ОУБ-ын шугамаар орж ирдэг “Дэээрэт” тэргэнцэрийг оруулж ирж байгаа. Хятадаас оруулж ирж байгаа тэргэнцэрийг бодвол арай дээр, гэхдээ эмнэлгийн зориулалттай хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулагдаагүй. Сүүлийн 3 жил Японы “Нинжин сан” мөн Японы тэргэнцэр засварын цехтэй хамтарч ажиллахыг хичээж байгаа. Япон иргэдийн хувьд өөрт тохирсон тэргэнцэрийг хийлгэж аваад 6 жил ашиглаад улсдаа буцааж өгдөг. Буцааж өгсөн тэргэнцэрүүдийг засварлаад буцааж олгодог эсвэл Азийн орнуудад тусламжаар хүргүүлдэг. Сүүлийн 3 жилийн хугацаанд тийм засварласан тэргэнцэрийг тусламжаар 2 удаа чингэлгээгээр оруулж ирсэн. Манай ажилтнууд тэр тусламжийн тэргэнцэрийг хэрэглэдэг.⁴⁴

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бэрхшээлийн онцлогт таарсан туслах хэрэгсэл, ортопед авах шаардлагатай байдаг ба тэргэнцэр нь гадаад улс орноос орж ирдэг бөгөөд тусламжийн хуучин тэргэнцэр л авахгүй бол шинэ хэрэглээний тэргэнцэр нь өндөр үнэтэй, нөхөн олговрын мөнгийг авах боломжгүй байдаг. Мөн бусад ортопед, тусгай хэрэгслүүдээс нийлүүлэгч байгууллагуудын оруулж ирж байгаа ортопед болон тусгай хэрэгсэл нь таарч тохирохгүй байх, амархан эвдрэх асуудал үүсдэг байна. Тиймээс ТББ-ын гишүүд ортопед, тусгай хэрэгслийг олгохдоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бэрхшээлийн онцлогт таарсан, хүний биед тохирсон байх, олон улсын туршлагаас харж нийгмийн халамжийн үйлчилгээний журмыг өөрчлөх зэрэг саналыг өгсөн.

Япон улсын туршлагаас харахад тэргэнцэр нь:

- Гар ажиллагаатай
- Цахилгаанаар ажилладаг
- Ердийн
- Спортын гэх төрлүүдтэй байдаг бөгөөд ихэнхдээ тусгай захиалгаар хийгддэг.

Япон улсын тэргэнцэр олгох журам:

- Японы нийгмийн халамжийн тогтолцоогоор, тэргэнцэр нь тусгай хэрэгсэлд ордог.
- Нарийн мэргэжлийн эмч ямар төрлийн тэргэнцэр олгох ёстойг шийддэг.
- Гар ажиллагаатай тэргэнцэр ойролцоогоор 250000-300000 иен
- Үүнээс иргэн өөрөө төлөх хувь 10 хувь

⁴⁴ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын гишүүнтэй хийсэн ярилцлагаас

- Эдэлгээний нас 6 жил

*Нийгмийн халамжаас тусгай хэрэгсэл, ортопед олгохдоо хэнд, ямар хэрэгцээ шаардлага байгааг тооцоо хийж үздэггүй. Бизнесийн хэлбэр болгосон. Японоос орж ирж байгаа хуучин тэргэнцэрийг хандивын шугамаар оруулж ирж байгаа учир үнэгүй авсан. Бодит зах зээлийн үнэ нь өндөр үнэтэй. Тайван, Солонгос гээд олон орны тэргэнцэр судалж үзсэн ч шинэ тэргэнцэр оруулж ирье гэвэл өндөр үнэтэй, тэрийг нийгмийн халамжийн зардлаар оруулж ирэх боломжгүй. Хамгийн хямд нь 6 сая төгрөг. Миний хэрэглэж байгаа тэргэнцэрийн зах зээлийн үнэ нь 4800 доллар. Хятадын гайгүй үйлдвэрийн тэргэнцэрүүд 2 сая төгрөгт орж ирдэг. Солонгос, Японы хуучин тэргэнцэрийг оруулж ирье гэвэл 1.5-2.0 сая төгрөг. Ийм тэргэнцэр оруулж ирвэл, дунд нь засвар хийгээд 5-8 жил хэрэглэнэ. Өдөр тутамдаа ажил хийдэг, тэргэнцэртэй ч гэсэн нийгмийн амьдралд идэвхтэй оролцдог иргэдийн хувьд нийгмийн халамжаас олгож байгаа тэргэнцэрийг хэрэглэх ямарч боломж байхгүй. Нуруу нугасны гэмтэлтэй, тархины саажилттай хүн нийгмийн халамжаас протез, ортопед болон тусгай хэрэгсэл авах гэхээр хэрэгтэй юм огт байдаггүй. Тиймээс зарим иргэдийн хувьд материалыг нь бүрдүүлээд тухайн байгууллагатай тохиролцож мөнгийг нь аваад өөрт хэрэгтэй юмаа авах тохиолдол гардаг.*⁴⁵

Эмчилгээний тэргэнцэрийг тухайн иргэн эмчилгээний явцад тодорхой цаг хугацаанд хэрэглэдэг бол хэрэглээний тэргэнцэрийг нуруу нугасны гэмтэлтэй иргэн насан туршдаа хэрэглэх шаардлагатай болдог. Нийгмийн халамж үйлчилгээний нэгдсэн мэдээллийн системд ортопед, тусгай хэрэгсэл авсан иргэдийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр ялган ямар хэрэгсэл авсан талаарх мэдээллийг харах боломжтой боловч бэрхшээлийн төрлөөр тоон мэдээг гаргах боломжгүй юм. Нийгмийн халамжийн сангаас олгож буй ортопед болон тусгай хэрэгслийн жагсаалтад тэргэнцэр нь насанд хүрэгчдэд зориулсан энгийн тэргэнцэр, хүүхдийн тэргэнцэр 2 төрөл байгаа ба насанд хүрэгчдэд олгож байгаа тэргэнцэр нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлийн төрөл хамаарахгүй хүн бүрт ижил эмчилгээний зориулалттай тэргэнцэрийг олгож байгаа нь тухайн иргэдийн бэрхшээлийн онцлогт нийцэхгүй, шаардлагагүй хэрэгсэл авах асуудал үүсгэж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэргэнцэр нь эмнэлгийн зориулалттай тэргэнцэр. Өдөр тутамдаа байнгын тэргэнцэр хэрэглэж байгаа иргэд хэрэглээний тэргэнцэр хэрэглэх ёстой. Энэ талаар бодлогод тусгаж өгөөгүй. Нийгмийн халамжаас олгож байгаа тэргэнцэрийг ахмад настан, түр чадвараа алдсан иргэд эмнэлгийн зориулалтаар л ашиглах боломжтой. Бид нарын хувьд хэрэглээний тэргэнцэрийг хэрэглэхийг хүсдэг. Энэ нь маш хөнгөн, богино зайд эргэлт хийх боломжтой байдаг. Хятадаас орж ирж байгаа хэрэглээний тэргэнцэр дунджаар 1.8 сая төгрөг байдаг.

*Нийгмийн халамжийн сангаас тэргэнцэр олгохдоо төрлөөр нь ялгаж өгөх хэрэгтэй. Ямар өвчтэй хүнд ямар тэргэнцэр хэрэгтэй вэ гэдгийг гаргаж өгөх хэрэгтэй. Тэргэнцэр нь тухайн хүний өвчний онош, биеийн өндөр, жин, дунд чөмөг, шилбэний уртыг хэмжиж байж тааруулж хийгдэх ёстой байдаг.*⁴⁶

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын төлөөлөл тэдгээрийн гишүүд ихэвчлэн хөдөлмөр эрхлэх боломжтой иргэд байдаг бөгөөд нуруу нугасны бэртэлтэй, саажилттай, оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд нийгмийн халамжийн сангаас олгож буй ортопед болон тусгай хэрэгслээс авах зүйлс цөөхөн байдаг талаар дурдсан. ХБИ нийт 61 нэр төрлийн ортопед, тусгай хэрэгслээс бүх хэрэгслийг авах шаардлага байдаггүй бөгөөд

⁴⁵ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын гишүүнтэй хийсэн ярилцлагаас

⁴⁶ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын гишүүнтэй хийсэн ярилцлагаас

нэн шаардлагатай хэрэгцээтэй нэг зүйл нь чанартай байх, ямар байгууллагаас авах нь сонголт хийдэг байх, бэрхшээлийн онцлогт нийцсэн хэрэгсэл олгодог байх зэрэг саналыг өгсөн. Ахмад настан, ХБИ-д ижил хэрэгсэл олголгүй бэрхшээлийн төрлөөр нь ялгаж өгч чанартай хэрэгсэл олговол дахин олгох хугацааг сунгах боломжтой бөгөөд хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэхийн тулд иргэдээс үнийн дүнгийн тодорхой хувийг гаргуулдаг байх хэрэгтэйг дурдсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн нэг болох Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоо нь нийт гишүүдийнхээ хүрээнд тусгай хэрэгслийн жагсаалтад багтах 10 нэр төрлийн хэрэгслийг нийлүүлдэг, хараагүй иргэдэд зориулсан үйл ажиллагааг тогтмол явуулдаг байгууллага юм. Тус төв нь мэдрэгчтэй цагаан таягыг Канад улсаас 23 доллараар оруулж ирдэг бол бусад бүтээгдэхүүнийг БНХАУ-ын үйлдвэртэй гэрээ байгуулан монгол, англи хэл дээр ажилладаг хэрэгслийг оруулж ирдэг байна. Ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагуудаас ихэнх нь хараагүйчүүдийн хэрэгсэл нийлүүлдэг ба англи хэлтэй хэрэгсэл оруулж ирэх, таяг нь амархан эвдрэх зэрэг асуудал үүсдэг.

Хараагүйчүүдийн төвийн үзэж байгаагаар хараагүй иргэдийн хэрэгслийг МХҮХ өөрсдөө дангаараа нийлүүлдэг байвал, чанар стандарт, ашиглах явцад асуудал үүсэхгүй ба тухайн хүнийхээ бэрхшээлд таарсан хэрэгслийг олгоно гэдэг саналыг өгсөн.

2019 онд 60-70 байгууллага сонгон шалгаруулалтад тэнцсэн байсан. Тэр байгууллагуудын таяг, цаг, бусад хэрэгслийг харахад үнэхээр чанар муу, мөн англи хэлтэй байна. Тухайн хүмүүс хараагүйчүүдийн зовлонг мэдэхгүй болохоор ойлгохгүй, тухайн цаг, таяг, халууны шил, даралтын аппаратыг хэрхэн яаж ашиглах талаар зааж өгөх заавар зөвлөгөө өгдөггүй. Хэтэрхий олон байгууллагууд байна. Нэг аймгийн жишээн дээр ярихад хараагүйчүүдийн холбооны гишүүн иргэн манайд хүсэлтээ тавиад тусгай хэрэгсэл авах гэхээр аймгийн нийгмийн халамжийн ажилтан тухайн аймагт шалгарсан, магадлан итгэмжлэгдсэн байгууллагаас ав гэж шахах тохиолдол байна. Энэ жилийн хувьд 2 ч тохиолдол гараад байна. Тухайн хүмүүст сонголт хийх боломжийг нь олгохгүй байна. Тэгш өрсөлдөх боломжийг нь хааж байна.

Манай нийлүүлдэг халууны шил, цаг, дизи тоглуулагч гэх мэт зүйлс нь монгол хэлтэй ашиглахад хялбар байдаг.⁴⁷

Хөдөө орон нутгийн иргэд ортопед, тусгай хэрэгсэл авахын тулд Улаанбаатар хотруу явах нь хүндрэлтэй байдаг тул тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагаас авахаас өөр сонголтгүй байдаг. Зарим иргэд мэдээлэлгүйгээс болоод үйлчилгээний үнийн хөнгөлөлтөд хамрагдаж чадахгүй байх асуудал үүсдэг. Мэдээлэл цуглуулалтын явцад хараагүй болоод 5 жил болсон иргэн мэдрэгчтэй таяг байдаг талаар ямарч мэдээлэл, ойлголтгүй байсан. Тиймээс МХҮХ-оос аймгуудын салбар холбоогоор дамжуулан мэдээллийг сайн түгээх шаардлагатай мөн орон нутгийн халамжийн мэргэжилтнүүд хэрэгцээтэй хүнд нь мэдээллийг түгээх хэрэгтэй. МХҮХ нь нийлүүлэгч байгууллагуудын жагсаалтад байгаа учир иргэд мэдээлэл сайн байвал чанартай хэрэгсэл нийлүүлж байгаа байгууллагыг сонгох бүрэн боломжтой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын төлөөллүүд нь ортопед, тусгай хэрэгслийг нийтэд нь ярих биш зөвхөн өөрсдийн хэрэгцээний талаар асуудлаа дэвшүүлэх, өөрт хэрэгтэй хэрэгслийг тодотгож ярих зэрэг нөхцөл байдал ажиглагдсан.

⁴⁷ МХҮХ-ны гишүүнтэй хийсэн ярилцлагаас

4.2 Үйлчилгээг хэрэгжүүлэгчид

Ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд хамрагдах иргэн сум/хорооны нийгмийн халамжийн мэргэжилтнээс бүрдүүлэх материалын талаар мэдээлэл авснаар шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж нийлүүлэгч байгууллагаас хэрэгслээ авдаг. Сум/хорооны нийгмийн халамжийн мэргэжилтнүүд, ХХҮГ/ХХҮГ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмадын асуудал хариуцсан мэргэжилтнүүд нь иргэдийн материалыг бүрдүүлж авдаг үйлчилгээг хэрэгжүүлэгч гол хүмүүс юм. Судалгаанд сонгогдсон аймаг, дүүргийн нийгмийн халамжийн мэргэжилтэн, сум/хорооны халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж үйлчилгээний зохион байгуулалт, үйлчилгээнд хамрагдаж буй иргэд, үйлчилгээг хэрэгжүүлэхэд үүсч буй хүндрэл бэрхшээл, санал гомдол, хяналтын талаарх мэдээллийг цуглуулсан.

Судалгаанд хамрагдсан нийгмийн халамжийн мэргэжилтнүүд нь тухайн нэгждээ 1-ээс дээш жил ажилласан, нийгмийн халамжийн байгууллагад 3-аас дээш жил ажилласан, үйлчилгээний талаар сайн мэдээлэлтэй байсан. Аймаг, дүүргүүдийн хувьд тус үйлчилгээнд маш их хүн хамрагдах хандлагатай байдаг ба ялангуяа ахмадууд их хамрагддаг байна.

Үйлчилгээнд хамрагдах иргэн бичиг баримт зөрчилгүй, эмчийн тодорхойлолт, ЭХК-ын шийдвэрээ авч ирсэн тохиолдолд үйлчилгээнд хамруулахгүй байх эрх зүйн үндэс байхгүй тул ахмад настан болгон ямар нэгэн хэрэгсэл авах хандлагатай байдаг. Налайх, Багахангай, Багануур дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллага байхгүй тул тухайн дүүргийн иргэд Улаанбаатар хотоос хэрэгслээ авдаг. Энэ нь хүндрэлтэй байдаг тул иргэд тус үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна. 2019 онд гэрээ байгуулсан байгууллагуудын гэрээний заалтад нийлүүлэгч байгууллага нь сурталчилгаа хийх, тараах үйл ажиллагааг зохион байгуулахгүй байхыг тусгаж өгсөн учир Налайх дүүргийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2017 онтой харьцуулахад эрс буурсан байна.

Зарим орон нутгийн хувьд тараах, сурталчилах үйл ажиллагаа явагдсан хэвээр байгаа ба түүвэрт сонгогдсон аймаг, сумдад хяналтын бүлэг үүсгэх зорилгоор ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдаагүй иргэн олдохгүй байх нь хамрагдалт их болохыг харуулж байсан.

Уг үйлчилгээнд иргэд их хамрагддаг. Ялангуяа ахмад настанууд их хамрагддаг. Манай суманд 190 ахмад настантай түүний 60 хувь нь ортопед, тусгай хэрэгслийн үйлчилгээнд байнга хамрагддаг. ХБИ-ийн хувьд сонсголын аппаратыг их авдаг. Нурууны ширэн, даавуун хамгаалалт их авч байна. Аймаг руу явж ортопед, тусгай хэрэгсэл авах, байгууллагуудын ирэхийг хүлээх, Улаанбаатар хот руу явж авах зэргээр үйлчилгээнд хамрагддаг.⁴⁸

Алслагдмал суманд амьдарч байгаа иргэд сумынхаа нийгмийн халамжийн мэргэжилтэнд хүсэлтээ гаргаж материалаа бүрдүүлж өгдөг бөгөөд нийгмийн халамжийн мэргэжилтэн аймаг руу материалыг нь явуулдаг. Хөдөө орон нутгийн иргэд аймгийн төвөөс очиж ортопед, тусгай хэрэгслээ авах ёстой байдаг бол зарим байгууллагууд жилдээ 1-2 удаа сумдуудаар тойрч иргэдийн захиалсан хэрэгслийг тараадаг тохиолдол гарсаар байна. Энэ нь гэрээний заалтыг зөрчиж байгаа боловч одоогоор ХХҮЕГ-т дээрх чиглэлийн нотлох баримттай гомдол санал ирээгүй байна.

Гэрээний заалтад байгууллага зохион байгуулалттайгаар сум, хороодоор явж ортопед, тусгай хэрэгсэл тараах үйл ажиллагаа явуулахгүй байхыг тусгаж өгсөн. Одоогоор ийм байгууллага тараах үйл ажиллагаа зохион байгуулж байна гэсэн

⁴⁸ Завхан аймгийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

гомдол ирээгүй байна. Нотлох баримттай гомдол ирсэн тохиолдолд захиалагчийн зүгээс гэрээг цуцлах эрхтэй. ⁴⁹

Нийгмийн халамжийн мэргэжилтнүүд иргэдэд ямар байгууллагаас хэрэгслээ авах талаар шууд зааварчилдаггүй ба нийлүүлэгч байгууллагуудын танилцуулах материалыг иргэдэд өгдөг. Иргэд ихэнхдээ өөрт ойрхон байгууллагаас ортопед, тусгай хэрэгслээ авдаг байна.

Ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдах иргэд

- Халамжийн сангаас ХБИ 3 жил, Ахмад настан 5 жил хэрэгсэл авсан эсэхийг шалгуулдаг
- Багийн даргын тодорхойлолт
- Нарийн мэргэжлийн эмчийн тодорхойлолт
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Өргөдлийн маягт
- Хос ортопед, хэрэгсэл бол ЭХК-ын шийдвэр
- Нэхэмжлэхээр авч байгаа бол байгууллагаас нэхэмжлэх
- Өөрөө төлбөрөө төлсөн бол төлбөр төлсөн баримт зэргийг бүрдүүлдэг байна.

Өөрөө төлбөрөө төлсөн иргэдэд нөхөн олговрыг тухайн сардаа багтааж олгодог.

Нийгмийн халамжийн мэргэжилтнүүд тус хөтөлбөр нь хэрэгцээтэй хүндээ хүрч байвал ач холбогдолтой үйлчилгээ гэж үзсэн бөгөөд зарим тохиолдолд танил талаараа эмчийн бичиг гаргуулах тохиолдол гардаг талаар дурдсан.

Уг үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо жил ирэх тусам өсөж байгаа тул нийслэлийн дүүргийн халамжийн хэлтэсүүд төлбөр төлсөн баримтаар олгохыг илүүд үзэж байна.

Ортопед, тусгай хэрэгслийн хүрэлцээ Улаанбаатар хотод сайн байдаг бол хөдөө орон нутагт зарим хэрэгсэл байхгүй тохиолдолд захиалах, Улаанбаатар хот руу явж авах зэргээр асуудал үүсдэг. Байгууллагууд жишиг үнийг баримталж ортопед, тусгай хэрэгслийг олгодог ба иргэд сонголын аппарат, тэргэнцэр, таяг зэрэг хэрэгсэл дээр зөрүү мөнгө төлөх тохиолдол гардаг.

Иргэдийн хамгийн их авдаг хэрэгсэл нь:



Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 1-2 байгууллагаас сонголт хийх боломжтой тул сонголт бага, хүрэлцээ муу, мэдээлэл муутай байдаг. Сумдад очиж байгаа байгууллага нь жагсаалтад байх бүх ортопед болон тусгай хэрэгслийг авч очдоггүй, иргэдийн түгээмэл авдаг цөөн нэр төрлийн хэрэгслүүд байдаг.

Байгууллагад тавих хяналт байхгүй. Анх тендер шалгаруулахдаа ямар бүтээгдэхүүн ямар ханштай байх талаар бид нар хянаад иргэдэд ийм байх ёстой гээд заагаад өгөхчхөөр чанар муу бүтээгдэхүүнийг байгууллагууд нийлүүлэхгүй байх боломжтой. Одоо бол бидэнд хяналт тавихад үнэхээр хэцүү байна ер нь л

⁴⁹ ХХҮЕГ-ын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

*хяналтгүй болж байна. Хяналтгүй болохоор нийлүүлэгч байгууллага аль болох хямд зүйлийг нь авч ирж нийлүүлдэг.*⁵⁰

Нийгмийн халамжийн мэргэжилтэн нь өөрөө ортопед, тусгай хэрэгслийн жагсаалтаас зарим хэрэгслийг юунд ашигладаг, ямар өвчтэй хүн хэрэглэдэг талаар мэдэхгүй байх тохиолдол гарсан. Мэргэжилтнүүд иргэдэд мэдээллийг сайн түгээдэг өдөрлөг, багийн хурал дээр мэдээлэл сайн түгээдэг гэсэн боловч иргэд жагсаалтад байгаа ортопед, тусгай хэрэгслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл байдаггүй. Мэдээлэл түгээх талаар журманд тусгай заалт байхгүй ба халамжийн мэргэжилтнүүд үйлчилгээний заавар журамд ямар өөрчлөлт орж байгааг тухай бүр олж мэдэхгүй бол тэр болгон сургалтад хамруулж танилцуулга хийдэггүй.

Нийгмийн халамжийн мэргэжилтнүүд дахин олгох хугацааны хувьд өөрчлөх санал өгөөгүй ба үйлчилгээг хавтгайруулахгүйн тулд 3 жил, 5 жил гэсэн хугацаа нь хангалттай байдаг. Ортопед, тусгай хэрэгслийг иргэд хэрхэн хэрэглэж байгаагаас эвдрэл нь хамаардаг гэж хариулсан. Иргэдээс гомдол санал төдийлөн ирдэггүй ч ширэн бүсний хувьд зах дээр 30000-70000 төгрөгийн үнэтэй зарагддаг бүстэй ижил бүс тарааж байна гэсэн яриа гардаг байна. Судалгааны явцад зарим хорооны халамжийн мэргэжилтнээс согог засах гутал, төрөл бүрийн чигийг 3 жилд нэг удаа олгож байгаа бөгөөд ХБХ 3 жил хүлээх нь хүндрэлтэй байгаа талаар дурдсан.

*Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд согог засах гутал дээр асуудал үүсдэг. Тухайн гутлыг хүүхдийн хөлд тааруулаад хийлгэж авдаг бол хүүхэд өсөхийн хэрээр гутал нь багадаж холгож өмсөж болохоо байдаг. Тэгэхээр дахин авах эрх нь үүсэхгүй гутлаа авч чадахгүй байх тохиолдлууд гардаг.*⁵¹

Нийгмийн халамжийн байгууллагаас үйлчилгээнд тавьж буй хяналт

Нийгмийн халамжийн газрын захиргаа, хяналтын албанаас үйлчилгээ бүрт хяналт тавьдаг. Хяналт хийхдээ тухайн иргэн шаардлагатай ортопед, тусгай хэрэгслээ авсан эсэх, ашиглаж байгаа талаар, асуудал үүссэн зэргийг хянадаг байна. Мөн ХХҮЕГ-аас бичиг баримтад хяналт тавьдаг. Нийлүүлэгч байгууллагуудад хийгдэж буй хяналт бага байдаг ба гэрээний заалтаа хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар дүүрэг, орон нутгийн халамжийн мэргэжилтнүүд мэдээлэлгүй байсан.

Халамжаас тавигдаж байгаа хяналтыг явуулахад байгууллагын тоо олон тул явахад цаг хугацааны хувьд хүнд болсон. Хяналтыг сайжруулах арга замууд олох л хэрэгтэй байх эсвэл байгууллага цөөлөөд чанартай бүтээгдэхүүнийг нийлүүлэх хэрэгтэй.

Үйлчилгээг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл

Ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг хэрэгжүүлэгчдийн хувьд хүндрэл бэрхшээл харьцангуй бага гардаг. Дараах цөөн хэдэн асуудал гардаг.

- Иргэд үйлчилгээний талаарх ойлголтгүй байдал
- Санхүүжилт бага орж ирдэг. Нийлүүлэгч байгууллага руу мөнгө шилжихгүй байх
- Иргэд материалаа дутуу бүрдүүлж ирэх, үүнээс болоод олон дахин явууллаа гэж бухимдах

Нийгмийн халамжийн мэргэжилтнүүд тус үйлчилгээг хэрэгцээтэй хүнд чанартай хэрэгслийг олгох, дахин олгох хугацааны хувьд өөрчлөх шаардлагагүй бөгөөд амьжиргааны түвшинг харж дийлэнх иргэдэд төлбөр төлсөн баримтаар ортопед, тусгай хэрэгслийг олговол хавтгайрахгүй байх боломжтой. Ортопед, тусгай хэрэгслийн жагсаалтад гар таяг,

⁵⁰ Завхан аймгийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

⁵¹ Налайх дүүргийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

өвдгөвч нь 10000 төгрөгөөр олгогддог бөгөөд ахмад настан болгон авах хандлагатай байдаг тул жагсаалтаас хасах, нийлүүлэгч байгууллага нь хэтэрхий олон, чанаргүй хэрэгсэл нийлүүлж байгаа байгууллагууд их байдаг тул байгууллагуудын тоог цөөлж хяналтыг сайжруулах, хөдөө орон нутагт ажиллаж байгаа байгууллагууд хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлэх зэрэг саналуудыг өгсөн.

4.3 Нийлүүлэгч байгууллага

2019 онд ХХҮЕГ-т ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэхээр нийт 79 байгууллага санал өгснөөс ерөнхий шаардлагыг хангасан 69 байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Нийт ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагаас 16 аймагт 24 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бол Говьсүмбэр, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудад суурьшилтай үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага байхгүй. Байгууллагуудын ихэнх нь тусгай хэрэгсэл нийлүүлж байгаа бөгөөд ортопедын хэрэгслээс нурууны хамгаалалтууд, өвдгөвч, харааны шил, контакт линзийг түлхүү нийлүүлж байна. Нийт 69 байгууллагын 9 нь сонсголын дижитал аппаратыг нийлүүлдэг. Үүнээс зөвхөн чих, хамар хоолойн чиглэлээр төрөлжсөн дан сонсголын аппарат нийлүүлдэг байгууллага 5 байна. Судалгааны явцад байгууллагуудаас түүвэрлэж үйл ажиллагаатай танилцан, ярилцлага хийсэн.

Нийлүүлэгч байгууллагууд нь ХХҮЕГ-ын сонгон шалгаруулалтын шаардлагыг хангасаны үндсэн дээр гэрээ байгуулснаар ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэх зөвшөөрөл авдаг. 2019 оны байгууллагын сонгон шалгаруулалтын материалд нийлүүлэх бүтээгдхүүний үнийн саналыг ирүүлсэн ч бүх байгууллагууд жишиг үнийн дагуу саналаа өгсөн байна. Судалгааны явцад ихэнх байгууллагууд жишиг үнийг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн саналыг өгсөн ба ялангуяа сонсголын аппарат нийлүүлдэг төрөлжсөн байгууллагуудын хувьд нилээн өндөр үнийн саналыг хэлж байсан.

Үйл ажиллагаа явуулаад 15 жил болж байна. Манай байгууллага 2004 онд байгуулагдсан. Нийгмийн халамжийн байгууллагатай 2009 оноос хойш хамтарч ажиллаж байна. Сонсголын аппаратны худалдаа, тохируулга, засвар үйлчилгээ гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. ЭМЯ-ны тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Дани улсын Widex брэндийн ISO олон улсын стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг оруулж ирдэг. Сүүлийн үед технологийн дэвшилтэд тулгуурлан хамгийн багадаа 950 мянгаас 6 сая төгрөгийн хоорондох 30 гаран төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлж байна. Жишиг үнийн хувьд манайд 350.0 мянган төгрөгийн аппарат байхгүй тул зөрүү мөнгийг иргэд өөрсдөө төлдөг. Дани улсаас 187 доллараар оруулж ирдэг. Бусад байгууллагуудыг харж байхад 10-20 долларын Хятадын бүтээгдэхүүнийг нийлүүлээд байдаг.⁵²

Нийлүүлэгч байгууллагууд гэрээний заалтад зааснаар баталгаат хугацааг олгож байгаа, гомдол санал төдийлөн ирдэггүй гэж хариулсан боловч ортопед, тусгай хэрэгсэл авсан иргэд баталгаат хугацаа өгсөн эсэх талаар мэдээлэл муу байсан. Сонсголын аппарат хийлгэсэн иргэд зөрүү мөнгө төлсөн байсан ба 1-2 жилийн баталгаат хугацааг олгосон гэж хариулсан.

Нийт 69 байгууллагын 12 нь 30-аас дээш нэр төрлийн ортопед, тусгай хэрэгслийг нийлүүлдэг бол Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, Эрхэм чанар ХХК нь дотооддоо үйлдвэрлэж байна.

Нийлүүлэгч байгууллагууд дүүргийн нийгмийн халамжийн хэлтсүүд, хороод дээр танилцуулга материалаа байршуулдаг бөгөөд нийгмийн халамжийн мэргэжилтнүүд иргэдэд жагсаалтад байгаа байгууллагуудыг танилцуулснаар өөрийн хэрэгцээтэй ортопед, тусгай

⁵² Ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагатай хийсэн ярилцлагаас

хэрэгслийг авдаг. Иргэд ихэнхдээ өөрийн гэрт ойрхон байгууллагаас авах хандлагатай байдаг байна. Судалгааны явцад хаяг тодорхойгүй, нийлүүлж байгаа бүтээгдэхүүн цөөн байгууллага байсан. Хамгийн ихдээ 61 нэр төрлийн ортопед болон тусгай хэрэгслээс 54-ыг нийлүүлж байгаа байгууллага байгаа бөгөөд бүтээгдэхүүнээ БНХАУ, БНСУ-аас оруулж ирдэг.

Манай байгууллага 2015 оноос хойш ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Өөрсдөө хийдэг тусгай хэрэгсэлүүд ч байна мөн Хятад, Солонгос улсаас ч оруулж ирдэг. Өөрсдөө бол саажилттай хүүхдийн тусгай хэрэгслийг хийдэг. Өөрсдөө хэмжээг нь авч нарийн хэмжээд үйлдвэрлэдэг. Сандал, ширээ, алхуулагч, зогсуулагч гээд хүүхдийн биеийн хэмжээнд таарсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа. Тэргэнцэрээс авахуулаад стандарт бүтээгдэхүүнийг тусгай хэрэгсэл үйлдвэрлэдэг үйлдвэрээс гэрээгээр нийлүүлж байгаа. Үнэ өртгийн хувьд манай бүтээгдэхүүнүүд бага зэрэг үнэтэй, бид хэрэглэгчдэд чанартай сайн бүтээгдэхүүн нийлүүлэх зорилготой тул чанар муу юм оруулж ирдэггүй. Иргэд үйлчилгээнд хамрагдахдаа зөрүү мөнгө төлдөг. Алхуулагч, зогсооч, тэргэнцэр дээр зөрүү өгдөг. Өөрсдөө хийдэг тусгай хэрэгслийн материалуудыг дотоодоосоо болон Хятадаас худалдаж авдаг.⁵³

Ортопед, тусгай хэрэгслийн нэр төрөл олон сонголт сайтай байснаар иргэд жишиг үнэд баригдахгүй сайн чанарын өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг зөрүү мөнгө төлж авах боломжтой байдаг. Ахмад настан, ХБИ тэргэнцэр, суултуур, алхуулагчыг хамгийн их авдаг ба тухайн хэрэгслээ тогтмол ашигладаг учир 5 жил, 3 жил хэрэглэх боломжгүй байгаа талаар дурдсан. Жишиг үнийг нэмээд чанартай бүтээгдэхүүн оруулж ирвэл хугацааг уртасгах боломжтой байна.

Хүүхэд сар тутмаар өсдөг. Жишээлбэл алхуулагч, зогсоогчийг хамаагүй өндөр хийж болохгүй, яг тааруулж хийх ёстой. Тийм учраас хүүхдийн бүтээгдэхүүнийг 2 жил ч юм уу, жил 6 сар болгож хугацааг багасгах хэрэгтэй байх. Ахмад настны хувьд тэргэнцэр, таяа, суултуур гээд өдөр тутам хэрэглэгдэж байгаа бүтээгдэхүүнийг 5 жилдээ нэг удаа авах нь арай л урт байна. Магадгүй 3 жилд нэг удаа ч юм уу тусгай хэрэгслээсээ шалтгаалаад хугацаа нь өөр байж болох юм.⁵⁴

Харааны бэрхшээлтэй иргэдийн хэрэгслийг нийлүүлдэг нийт 17 байгууллага байгаагаас МХҮХ, Хараагүй хүмүүсийн инновацийн хөгжлийн төв нь хараагүй иргэдийн хэрэгслийг оруулж ирдэг төрөлжсөн байгууллага байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудаас хараагүй иргэдийн хэрэгсэл, сонсголын дижитал аппарат нийлүүлдэг байгууллага цөөн байна. Тиймээс иргэд ихэнхдээ Улаанбаатар хотоос ирж авах шаардлагатай болдог.

Нийгмийн халамжийн байгууллагаас нийлүүлэгч байгууллагуудад тавьж буй хяналт

Нийлүүлэгч байгууллагууд сонгон шалгаруулалтад оролцохдоо тавьсан шаардлагын дагуу материалаа бүрдүүлж ирүүлдэг ба гэрээнд заасан гүйцэтгэгч талын эрх, үүргийг шалгаж ХХҮЕГ-аас хяналтыг тогтмол тавьдаг. Мөн сар бүр байгууллагуудаас үйл ажиллагааны тайланг явуулдаг. Нийлүүлэгч байгууллагуудын хувьд ХХҮЕГ-аас болон аймаг, дүүргийн халамжийн хэлтэсүүдээс хяналтыг тогтмол тавьдаг байна.

Хүндрэл бэрхшээл

Ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагуудад үйлчилгээг хэрэгжүүлэхэд дараах хүндрэл гарч байна.

⁵³ Ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагатай хийсэн ярилцлагаас

⁵⁴ Ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагатай хийсэн ярилцлагаас

- Нэхэмжлэхээр олгосон хэрэгслийн мөнгө орж ирэхгүй удах;
- Зарим ХБИ-тэй харилцахад ойлголтын зөрүү үүсэх;
- Иргэдийн бүрдүүлэх материал их, олон дахин явах хүндрэлүүд гардагаас гадна

Нэг бүтээгдэхүүнийг олон байгууллага нийлүүлэх нь чанарын хувьд ялгаатай байх, үнийн дүн өөр байх зэрэг нь нийтээрээ чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлдэг гэх асуудлыг үүсгэж байна.

4.4 Ортопед болон тусгай хэрэгслийн үнэ

2012 онд Засгийн газрын тогтоолоор Протез, ортопед болон тусгай хэрэгслийн жишиг үнийг тогтоосон бөгөөд 2017 онд журамд өөрчлөлт оруулсан ч жишиг үнэд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 6. Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ

Ортопедын хэрэгсэл					
№	Согог засах гутал	Жишиг үнэ	№	Нуруу, хүзүүний хамгаалалт	Жишиг үнэ
1	Өвлийн гутал /захиалгаар/	150.0	9	Нурууны ширэн хамгаалалт	150.0
2	Өвлийн гутал /стандарт/	300.0	10	Нурууны даавуун хамгаалалт	60.0
3	Хавар, намрын гутал /захиалгаар/	120.0	11	Нурууны хуванцар хамгаалалт	250.0
4	Хавар, намрын гутал /стандарт/	250.0	12	Нурууны бэхэлгээ	600.0
5	Зуны гутал	120.0	13	Хүзүүвч	50.0
6	Өндөрлөгтэй улавч	50.0	14	Хүзүүний бэхэлгээ /зөөлөн/	30.0
7	Пронатор, супинатор улавч	25.0	15	Хүзүүний бэхэлгээ /хатуу/	50.0
8	Өвдгөвч	10.0	16	Ивэрхийн даруулга	30.0

Согог засах гутал, улавч, нуруу, хүзүүний хамгаалалтыг “Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв”, “Эрхэм чанар” ХХК, нар захиалгаар хийдэг бол бусад нийлүүлэгч байгууллагууд согог засах гутал, улавчийг БНХАУ-аас захиалгаар оруулж ирж нийлүүлдэг. Хөдөө орон нутагт нийлүүлэгч байгууллагуудад согог засах гутал, улавч байдаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс илүүтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд согог засах гутлыг түлхүү авдаг бөгөөд нийгмийн халамжийн сангаас үнийн хөнгөлөлтөөр авахын тулд иргэд ихэвчлэн “Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв”-өөс авдаг. Тус төв нь ХБИ, ХБХ-ийн протез, ортопед үйлдвэрлэдэг улсын үйлдвэр ба мэргэжлийн техникч тухайн иргэний бэрхшээлийн онцлогт тааруулж хөлийн хэмжээг авч стандартын дагуу хийдэг.

ХБХ-ийн тусгай, нумтай зарим гутлын хувьд иргэд зөрүү мөнгө төлж авдаг. Хүүхдийн бие жил ирэх тусам томорч хөгжиж байдаг тул нэг гутлыг 3 жил өмсөх боломжгүй байдаг. Иргэдийн хувьд СЗСҮТ-ийн захиалгын дараалал, гутлын загвараас шалтгаалж сүүлийн жилүүдэд хүүхдийн согог засах гутлыг гадны улсуудаас захиалж авах хандлагатай байна. Захиалгаар согог засах гутал, улавч авсан тохиолдолд нийгмийн халамжийн сангийн үнийн хөнгөлөлтөд хамрагдах боломжгүй юм. Орон нутгийн ХБИ, ХБХ-ийн хувьд согог засах гутал, улавч хэрэглэх тохиолдол цөөхөн байсан ба энэ нь хүндрэл ихтэй нөгөө талаар иргэдийн мэдээлэлгүй байдал нөлөөлж байгаа нь ажиглагдсан.



Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв
120.0-300.0



БНХАУ-аас оруулж ирдэг гутал
160.0-280.0



Нумтай гутал онлайн захиалга
120.0-150.0

“Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв”, “Эрхэм чанар” ХХК нь жишиг үнийн дагуу гутал, улавчийг үйлдвэрлэж нийлүүлдэг ч сүүлийн жилүүдэд материалын үнэ өндөр болсон тул жишиг үнийг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байгааг дурдсан. Мөн үйлдвэрийн ажилчид цөөн, гар ажиллагаа ихтэй тул нэг гутал хамгийн багадаа 1 сарын хугацаанд бэлэн болдог байна. Нурууны ширэн бүс, даавуун бүсийг байгууллагууд ихэвчлэн БНХАУ-аас оруулж ирдэг ба зарим тохиолдолд дотоодын үйлдвэрийн бүсийг нийлүүлдэг. “Сэргээн засах, сургалт, үйлдвэрлэлийн төв” бэлдэц материалаа тендерт шалгарсан байгууллагаас нийлүүлж өөрсдөө үйлдвэрлэдэг байна. Ширэн бүсний жишиг үнэ нь 65.0-150.0 төгрөг боловч ихэнхдээ байгууллагууд 150.0 төгрөгөөр нийлүүлдэг.



Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв 150.0



Зах зээлийн үнэ

35.0-65.0

“Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн үндэсний төв” нурууны бэхэлгээ, нурууны хуванцар хамгаалалт, даавуун хамгаалалт, хүзүүвч, хүзүүний бэхэлгээг тухайн иргэний бэрхшээлийн онцлог, гэмтэлд тааруулж хэмжээ авч захиалгаар хийдэг бөгөөд ширэн бүсний түүхий эд буюу үхрийн ширийн үнэ өссөнтэй холбоотой орц, материалын үнэ өндөр гардаг. Судалгааны явцад ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагаас зураг дээрх бүсийг нийлүүлж байгаа тохиолдол гарсан ба тухайн бүсний зах зээлийн үнэ нь 35.0-65.0 мянган төгрөг байна.

Хүснэгт 7. Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ

Ортопедын хэрэгсэл					
№	Төрөл бүрийн чиг	Жишиг үнэ	№	Бусад хэрэгсэл	Жишиг үнэ
17	Хөлийн чиг /урт/	300.0	25	Павликийн дөрөөвч /захиалга/	25.0-50.0
18	Хөлийн чиг /богино/	200.0	26	Павликийн дөрөөвч /стандарт/	50.0
19	Гарын чиг	50.0-150.0	27	Бөөрний бандааж	20.0
20	Шууны чиг	50.0	28	Сонсголын дижитал аппарат	350.0
21	Бугалганы чиг	150.0	29	Харааны шил	15.0
22	Шагайн чиг	90.0	30	Контактны линз	100.0
23	Суга өргөгч чиг	80.0-150.0	31	Компьютерийн ярьдаг программ хангамж	200.0
24	Гар, хөлийн спилен	35.0	32	Алхуулагч	50.0

Төрөл бүрийн чигийг дотооддоо үйлдвэрлэж байгаа 2 байгууллага байгаа бөгөөд бусад байгууллагуудын хувьд ихэнхдээ БНХАУ-аас оруулж ирдэг. Хөлийн чигийг бэрхшээлийн онцлогт тохируулж, хэмжээ авч хийдэг бол БНХАУ-аас оруулж ирж байгаа чигний хувьд тухайн иргэний биед таарахгүй байх, чийг татах зэрэг асуудал үүсдэг. Сонсголын дижитал аппарат нийлүүлдэг байгууллагууд 9 байдаг бөгөөд Дани, Герман, Сингапур, БНСУ, БНХАУ зэрэг улсуудаас оруулж ирдэг. Судалгааны явцад сонсголын аппарат нийлүүлдэг 3 байгууллагын үйл ажиллагаатай танилцсан ба үнийн хувьд 200.0 мянган төгрөгөөс 14 сая хүртэлх төгрөгийн үнэтэй бүтээгдэхүүнийг оруулж ирдэг. Сонсголын аппаратыг хөдөө орон нутгийн иргэд ихэнхдээ Улаанбаатар хотод ирж хийлгэдэг ч зарим тохиолдолд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагаас авдаг. Сонсголын аппаратыг Улаанбаатар хотод ирж хийлгэж байгаа иргэд ихэнхдээ зөрүү мөнгө төлж хийлгэсэн бөгөөд 1-2 жилийн баталгаат хугацааг өгдөг байна. Орон нутгаас авсан

иргэдийн сонсголын аппарат нь ажиллахгүй болох, баттерей нь муудах, бороо усанд норж шуугих зэрэг асуудлууд гардаг байна.



Сонсголын аппарат 1

350.0-14 сая

Сонсголын аппарат 2

950.0-6 сая

Сонсголын аппарат 3

150.0-550.0

ХХҮЕГ-аас жил бүр сонгон шалгаруулалт явуулж ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэх шаардлага хангасан байгууллагуудыг сонгож гэрээ байгуулдаг. Байгууллагууд сонгон шалгаруулалтад орохдоо санал болгож буй бараа бүтээгдэхүүний үнийн саналыг ирүүлдэг. Байгууллагуудын ирүүлсэн үнийн санал нь жишиг үнийн дагуу байдаг боловч судалгааны явцад дийлэнх байгууллагууд жишиг үнийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагатай байна гэсэн саналыг өгсөн. Ялангуяа сонсголын аппаратыг Герман, Дани улсаас үнэтэй оруулж ирдэг байгууллагуудын хувьд жишиг үнээр олгоход хүндрэлтэй байдаг. Иргэд сайн чанарын 4 сувагтай, усны хамгаалалттай сонсголын аппарат авахад 1 сая төгрөгөөс дээш үнэтэй байдаг тул зөрүү мөнгө төлж авж байна.

Хүснэгт 8. Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ

Ортопедын хэрэгсэл					
№	Төрөл бүрийн таяг, бусад хэрэгсэл	Жишиг үнэ	№	ХБХ хэрэгсэл	Жишиг үнэ
33	Модон таяг	15.0	47	Тэргэнцэр /насанд хүрэгсэд/	150.0
34	Төмөр суга таяг /хос/	40.0	48	Тэргэнцэр /энгийн/	200.0
35	Тохойн тулгууртай таяг /хос/	40.0	49	Тэргэнцэр /атгагч, хэвтдэг/	600.0
36	Гар таяг	10.0	50	Хүүхдийн цээживч	400.0
37	Цагаан таяг /хараагүй хүний/	60.0	51	Эмчилгээний бөмбөг /зуйван/	80.0
38	Мэдрэгчтэй цагаан таяг	120.0	52	Эмчилгээний бөмбөг	60.0
39	Хараагүй хүний брайль хэрэгсэл	100.0	53	Хүүхдийн алхуулагч	120.0
40	Дизи тоглуулагч	520.0	54	Тамбформ	50.0
41	Брайль цаг	30.0	55	Гарын анчер	280.0
42	Бичиг томруулагч линз	30.0	56	Зогсоогч	160.0
43	Ярьдаг халууны шил	50.0	57	Тавцантай ширээ	160.0
44	Ярьдаг цаг	25.0	58	Хөтөвч суултуур /насанд хүрэгсэд	80.0
45	Ярьдаг даралтны аппарат	150.0	59	Хөтөвч суултуур /хүүхэд/	12.0
46	Радио хүлээн авагч	50.0	60	Стомын уут /хүүхэд, насанд хүрэгсэд/	720.0

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгслүүдийн үнэ өндөр байгаа боловч хүүхдийн хөгжил тогтмол явагдаж байдаг тул 3 жил хүлээх хүндрэлтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамгийн их авдаг хэрэгсэл нь эмчилгээний бөмбөг, тэргэнцэр, алхуулагч байна.

4.4.1 Нийлүүлэгч байгууллагын үнийн санал

Судалгааны явцад нийлүүлэгч байгууллагууд жишиг үнийг хэрэгсэл тус бүр дээр нэмэгдүүлэх саналыг өгч байсан ба ямар хэрэгсэл дээр үнийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг тодруулсан. Иргэдийн хамгийн их авдаг хэрэгсэл болох сонсголын аппарат, тэргэнцэр, суултуур, алхуулагч, хүүхдийн хэрэгслүүд дээр үнийг нэмэгдүүлэх хэрэгтэй байгааг ихэнх байгууллага дурдсан.

Тэргэнцэрийг байгууллагууд ихэнхдээ БНХАУ-аас оруулж ирдэг бөгөөд 140.0 төгрөгөөр оруулж ирдэг тул ашиг байдаггүй, тэргэнцэрийн үнийг нэмэх шаардлагатай гэсэн саналыг өгсөн.

Зураг 19. СЗСҮТ, Эрхэм чанар ХХК-ны үнийн санал

Жишиг үнэ	Ортопед, тусгай хэрэгсэл	Үнийн санал		Нэмэгдэх хэмжээ
120.0-300.0	Согог засах гутал	200.0-380.0	↑	80.0
25.0-50.0	Төрөл бүрийн улавч	25.0-100.0	↑	50.0
60.0-250.0	Нурууны хамгаалалт	120.0-450.0	↑	60.0-200.0
50.0-300.0	Төрөл бүрийн чиг	80.0-500.0	↑	30.0-200.0
25.0-150.0	Согог засах бусад хэрэгсэл	50.0-350.0	↑	25.0-200.0
35.0-600.0	Хүүхдийн хэрэгсэл	50.0-850.0	↑	15.0-250.0

СЗСҮТ, Эрхэм чанар ХХК нь протез, ортопед, тусгай хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэдэг үйлдвэр бөгөөд орц материалын үнэ нэмэгдсэн учир дараах хэрэгслүүдийг нэмэгдүүлэх саналыг өгсөн. СЗСҮТ ортопед, тусгай хэрэгсэл хийх түүхий эд, материал авахдаа жил бүр тендер зарладаг тул тендерт орж байгаа байгууллагын түүхий эдийн үнэ тогтмол өсч орж ирдэг. Хэдийгээр протез, ортопедын хэрэгслийг тухайн хүний биеийн онцлогт тааруулж үйлдвэрлэдэг ч 13 ажилтантай үйлдвэрийн хэмжээнд үндсэн техникч нэг байдаг тул хэрэгсэл захиалсан иргэд хүлээх, дараалал их байх асуудал үүсдэг.

Судалгааны явцад орц, материалын үнэ болон нийлүүлэгч байгууллагын ортопед, тусгай хэрэгслийн оруулж ирж байгаа үнэтэй танилцах гэсэн боловч дийлэнх байгууллагууд тодорхой хариулт өгөөгүй. Тиймээс байгууллагын өгсөн үнийн саналаар жишиг үнийг шууд нэмэгдүүлэх нь учир дутагдалтай юм. Сонсголын аппарат нийлүүлдэг байгууллагууд бусад улс орноос өндөр үнэтэй оруулж ирдэг тул үнийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн саналыг өгсөн.

Бодит хөнгөлөлт болж чадахгүй байна. Цаашид үнийг нэмэгдүүлэх шаардлагатай. Иргэдийн төлөх зөрүү төлбөрийг аль болох бага байхаар шийдэж өгөх хэрэгтэй. Гэхдээ компани болгоны оруулж ирж байгаа аппаратууд хаанаас орж ирж байгаа, ямар хүчин чадалтай гээд бүх зүйлээрээ ялгаатай. Уг нь тухайн хүмүүс үнэтэй маш сайн чанарын аппарат авчихвал доод тал нь 6-9 жил хэрэглэнэ.⁵⁵

Үнийг нэмэгдүүлээд чанартай сонсголын аппарат олговол дахин олгох хугацааг уртасгах боломжтой. Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ 2012 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш 6 жилийн хугацаанд жишиг үнэ нэмэгдээгүй. Үнийн тогтвортой байдал гэж мөнгө үнэ цэнээ тогтвортой хадгалж, үнэ тогтмол байхыг хэлдэг. Гэтэл ямар ч улсын эдийн засаг дахь хэрэглээний үнэ байнга тогтвортой байдаггүй тул бараа, ажил, үйлчилгээний үнэ өөрчлөгдөж байдаг. Ханш уналтын үр нөлөө нь мөнгөний үнэ цэний өөрчилдөг. Инфляци нэмэгдэхийн хэрээр төгрөгийн худалдан авах чадвар буурдаг. Инфляцийн түвшин жил бүр өсч байгаа ч Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ 2012 оноос хойш өөрчлөгдөөгүй байна. Иймд 2012 оны зарим хэрэгслийн үнийн дүнг инфляцаар засварлаж одоогийн худалдан авах чадварыг гаргасан.

⁵⁵ Ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагатай хийсэн ярилцлагаас

Зураг 20. Ортопед, тусгай хэрэгслийн үнийг инфляцаар засварласан дүн



Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгийн их авдаг сонсголын аппарат болон суултуурын үнийг засварлаж тооцвол сонсголын аппаратны хувьд 2012 оноос хойш батлагдсан жишиг үнээр буюу 350.0 төгрөгөөр олгогдож байгаа бөгөөд 2018 оны инфляцаар засварлавал 558.3 төгрөг, харин суултуур 127.6 төгрөг байна.

Хүснэгт 9. Ортопед, тусгай хэрэгслийн үнийг инфляцаар засварласан дүн

	Ахмад/ХБИ			
	Тэргэнцэр /хүүхэд/	Тавцантай ширээ	Хүүхдийн алхуулагч	Тэргэнцэр
2012	600000	160000	120000	150000
2013	685800	182880	137160	171450
2014	757809	202082	151562	189452
2015	854809	227949	170962	213702
2016	911226	242994	182245	227806
2017	917604	244695	183521	229401
2018	957061	255216	191412	239265

ХБИ, ХБХ-ийн хамгийн их авдаг хэрэгслийн үнийг 2018 оны инфляцаар засварлаж одоогийн худалдан авах чадварыг гаргасан. 2012 оноос хойш ортопед, тусгай хэрэгслийн үнийг нэмээгүй, зарим хэрэгслийн хувьд үнийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгаа ч журмын хувьд өөрчлөлт оруулах саналыг нийгмийн халамжийн мэргэжилтнүүд, ТББ-ийн төлөөлөлүүд гаргасан. 2018 онд протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэд өөрчлөлт оруулах чиглэлээр тооцоо судалгаа хийх ажлын хэсэг байгуулагдсан ба аймаг дүүргийн ХХҮГ-аас санал авсан байна.

Аймаг, дүүргүүд ихэнх ортопед, тусгай хэрэгсэл дээр жишиг үнийг нэмэгдүүлэх хэрэгтэй ч шалгуурыг өндөр болгох, бэрхшээлийн онцлогт таарсан хэрэгслийг хэрэгтэй хүнд нь өгөх шаардлагатай гэсэн саналыг өгсөн байна. ХБИ, ХБХ-д олгох ортопед, тусгай хэрэгслийн үнийг нэмэх шаардлагатай ба иргэдийн хамгийн их авдаг, үнийн дүн бага гар таяг, өвдгөвч зэрэг нь үйлчилгээг хавтгайруулах хандлагатай, мөн үйлчилгээ үзүүлэхэд ачаалал үүсгэж байгааг ихэнх халамжийн газрууд дурдсан байна. Стомын уут нь хагалгаанд орсон тогтмол хэрэглэдэг иргэдийн хувьд 3 жилд нэг удаа авах нь хангалтгүй байна. Иймээс ортопед, тусгай хэрэгслийг олгохдоо ХБИ, ХБХ-ийг бэрхшээлийн төрлөөр тодорхойлж шаардлагатай хэрэгслийг олгож байх, ахмад настныг нарийн мэргэжлийн эмч өвчний тодорхойлолтыг тодорхой гаргаж хэрэгслийг олгох, үйлчилгээг хавтгайруулж байгаа үнийн дүн бага зарим хэрэгслийг хасах саналуудыг аймаг дүүргийн халамжийн газар, хэлтсүүдээс гаргасан байна.

5 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 Дүгнэлт

Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ – Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт судалгааг үйлчилгээнд оролцогч талууд болох нийгмийн халамжийн мэргэжилтэн, ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын төлөөлөл, үйлчилгээнд хамрагдсан иргэн болон хамрагдах хүсэлтэй иргэдийн үйлчилгээний талаарх санал бодол, тэдэнд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулан чанарын судалгааны аргаар хийж гүйцэтгэлээ.

2018 оны жилийн эцсийн байдлаар ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд нийт 48 193 иргэн хамрагдаж өмнөх оноос 13 086 иргэнээр нэмэгдсэн байна. Нийт хамрагдсан иргэдийн 75.5 хувийг ахмад настан эзэлж байна. Өмнөх жилтэй харьцуулвал үйлчилгээнд хамрагдсан ахмад настан огцом нэмэгдсэн байна. 2019 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр нийт хамрагдсан иргэдийн 80.9 хувь нь ахмад настан байна.

Ахмад настнуудын хамгийн их авсан хэрэгслийн 39.4 хувийг өвдгөвч, нурууны ширэн хамгаалалт, гар таяг эзэлж байгаа бол ХБИ-ийн хамгийн их авсан хэрэгслийн 15.4 хувийг өвдгөвч, нурууны ширэн хамгаалалт, гар таяг эзэлж байна.

Үйлчилгээнд хамрагдсан иргэд үйлчилгээний талаарх мэдээлэл муу байна. Энэ нь хөдөө орон нутагт түлхүү ажиглагдаж байсан. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад байгаа тусгай хэрэгслээс өөр тусгай хэрэгслийн талаар мэдээлэлгүй, хаанаас авж болох, юунд ашигладаг талаар мэдэхгүй байна.

Иргэд үйлчилгээнд хамрагдахдаа ихэнхдээ тухайн байгууллагаас нэхэмжлэх авч тусгай хэрэгсэл авдаг бол хүүхдийн хэрэгсэл, сонсголын аппарат, тэргэнцэрийг өөрсдөө худалдаж аваад үнийн хөнгөлөлтөд хамрагддаг байна. Ялангуяа иргэд сонсголын аппаратыг авахдаа эхлээд төлбөрөө төлөх, зөрүү мөнгө төлөх тохиолдол их байна. Иргэд уг үйлчилгээнд хамрагдахад хүндрэл бага гардаг ба хөдөө орон нутгийн иргэдийн хувьд аймгийн төв орж тусгай хэрэгслээ авахад хүндрэлтэй байна. Зарим аймагт нийлүүлэгч байгууллагууд сумдуудаар тойрч ортопед, тусгай хэрэгслийг тараах асуудлыг гаргасаар байна. Энэ нь нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний заалтыг зөрчиж байгаа бөгөөд хяналт, хариуцлагын тогтолцоо муу байгааг харуулж байна.

Иргэд материал бүрдүүлэлт, ортопед болон тусгай хэрэгсэл авахад хугацаа бага зарцуулдаг бөгөөд ихэнх иргэд тус үйлчилгээ нь маш их ач холбогдолтой үйлчилгээ гэж үзсэн. Зарим ортопед, тусгай хэрэгслийн хувьд амархан эвдрэх, биед тохиромжгүй байх асуудал үүсдэг ч хэрэглэж байгаа нөхцлөөс шалтгаалдаг байна. Жишээ нь тэргэнцэрийг ахмадууд зөвхөн гарахдаа ашигладаг бол ХБИ, ХБХ-ийн хувьд тогтмол ашигладаг учир амархан эвдэрдэг байна. Хамгийн их асуудал тулгардаг хэрэгслүүд нь хүүхдийн хэрэгслүүд мөн сонсголын дижитал аппарат, суултуур, тэргэнцэр байна.

Үйлчилгээнд хамрагдаж чадаагүй иргэдийн хувьд үйлчилгээний талаар мэдээлэл байхгүй, өөрөө эхэлж төлбөрөө төлөх болон зөрүү төлбөр төлөх боломжгүй, шаардлагатай ортопед, туслах хэрэгсэл нь орон нутагт нь байхгүй, Улаанбаатар хот явж захиалах, авах боломж байхгүй зэрэг шалтгаанаар үйлчилгээнд хамрагдаж чадаагүй байна.

Ихэнх тохиолдолд мэдээлэл байхгүйгээс шалтгаалан үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй бөгөөд хөдөө орон нутгийн иргэд сонсголын аппарат, согог засах гутал, чиг зэрэг захиалгаар хийх боломжтой бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотод очиж хийлгэх боломжгүйгээс хамрагдаж чаддаггүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын гишүүд нийгмийн халамжийн сангийн үнийн хөнгөлөлтөөр олгож байгаа ортопед, тусгай хэрэгслээс хэрэглэж байгаа зүйл цөөн байдаг ба гол хэрэглэдэг тусгай хэрэгсэл нь тэргэнцэр байна. Ихэнхдээ өөрөө худалдаж авсан, тусламжийн байгууллагаас орж ирсэн тэргэнцэрийг хэрэглэдэг. ХБИ бүр ялгаатай хөгжлийн бэрхшээлтэй байдаг бөгөөд өдөр тутамдаа тусламж аваад хэвтрийн байхыг хүсдэггүй байна. Ажил хийх боломжтой иргэд олон байдаг ба тэдэнд сайн чанарын тэргэнцэр, эсвэл бэрхшээлийн онцлогт таарсан сайн чанарын туслах хэрэгсэл хэрэгтэй байдаг. Нийгмийн халамжийн сангаас үнийн хөнгөлөлтөөр олгож байгаа тэргэнцэр нь эмчилгээний зориулалттай тул тогтмол хэрэглэх боломжгүй байдаг. Хэрэглээний тэргэнцэрийн зах зээлийн үнэ нь маш өндөр байдаг тул тусламжаар орж ирсэн хуучин тэргэнцэрийг олж авдаг. ХБИ-ийн саналаар ортопед, тусгай хэрэгслийн үнийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгаа ч журманд өөрчлөлт оруулж ахмад настан, ХБИ олгох хэрэгслийг бэрхшээлийн төрлөөр тодорхой ялгаж өгөх хэрэгтэй. Мөн чанартай, өөрт нэн шаардлагатай хэрэгслийг авахад улсаас 100 хувь үнийг хөнгөлөхгүй, иргэн өөрөө тодорхой хувийг төлдөг байх нь иргэдийг хариуцлагатай болгох давуу талтай байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн системд бүртгэгдсэн ортопед, тусгай хэрэгсэл авсан иргэдийн тоон мэдээллийг харахад тус үйлчилгээнд 2018, 2019 оны эхний хагас жилийн байдлаар ХБИ бага хамрагдсан байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт хамрагдсан иргэдийн 19.1 хувийг ХБИ эзэлж байгаа бол 80.9 хувь нь ахмад настан байна.

Нийгмийн халамжийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар тус үйлчилгээ нь жил ирэх тусам хавтгайрах хандлагатай байгаа бөгөөд ялангуяа ахмад настнуудын хувьд эмчийн бичигтэй бол хамрагддаг талаар дурдсан. Халамжийн мэргэжилтнүүд иргэдэд мэдээллийг сайн түгээдэг ч судалгааны явцад зарим хорооны халамжийн мэргэжилтэн ортопед, тусгай хэрэгслийн жагсаалтад байх хэрэгслээс зарим нэр төрлийн хэрэгслийг юунд ашигладаг талаар мэдэхгүй байх тохиолдол гарсан.

2019 онд нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ байгуулснаар зарим дүүргүүдийн хувьд үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо багасаж, шаардлагатай хүндээ хүрч байгаа боловч хөдөө орон нутгийн хувьд үйлчилгээний хамрагдалт их хэвээр байна. ХХҮЕГ-аас төлбөр төлсөн баримтаар ортопед, тусгай хэрэгсэл олгох зааврыг өгч байгаа нь хөдөө орон нутгийн иргэд, алслагдмал дүүргүүдийн хувьд хүндрэл бэрхшээлтэй байна. Халамжийн мэргэжилтнүүд дахин олгох хугацааг хангалттай гэж үзсэн. Мөн үнийн дүн багатай гар таяг, өвдгөвч гэх хэрэгслийг жагсаалтаас хасах саналыг дийлэнх мэргэжилтнүүд өгсөн. Стомын уутыг нийлүүлэх байгууллагууд цөөн байдаг ба үнийн дүн өндөр тул иргэд өөрсдөө худалдаж авч чадахгүй тохиолдол их байна. Тиймээс ортопед, тусгай хэрэгсэл тус бүр дээр ХБИ, ХБХ, ахмад настанд олгох хугацаа, үнийн дүнг зааж өгөх саналыг гаргасан.

2019 онд ХХҮЕГ-аас 69 байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд үүнээс 24 байгууллага хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Зарим аймагт 2 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бол Говьсүмбэр, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудад тогтмол суурьшилтай, нийлүүлэгч байгууллага байхгүй байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд зарим нэр төрлийн ортопед, тусгай хэрэгсэл байхгүй байх нь иргэдийг хот руу явж хэрэгслээ авах, захиалаад удаан хугацаанд хүлээх зэрэг хүндрэлүүдийг дагуулж байна. Нийлүүлэгч байгууллагууд сонгон шалгаруулалтад оролцоходоо үнийн санал ирүүлсэн боловч сонгон шалгаруулалтад тэнцэхийн тулд байгууллагууд жишиг үнийн дагуу ирүүлсэн байна. Гэвч судалгаанд хамрагдсан байгууллагууд жишиг үнийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа талаар 100 хувь санал нэгтэй байна. Ялангуяа сонсголын аппарат, тэргэнцэрийн үнийг нэмэгдүүлэх саналтай байсан.

Дотооддоо протез, ортопед, тусгай хэрэгсэл үйлдвэрлэдэг үйлдвэр 2 байсан ба түүхий эдийн үнэ өссөнтэй холбоотой бүх хэрэгслийн үнийг нэмэгдүүлэх саналыг өгсөн. Нийлүүлэгч байгууллагууд гэрээний заалтад заасны дагуу баталгаат хугацааг олгож байгаа боловч иргэдийн дунд баталгаат хугацааны талаарх мэдээлэл муу байна. Нийт 61 нэр төрлийн тусгай хэрэгслээс 30-аад нэр төрлийн хэрэгсэл нийлүүлж байгаа байгууллага 12 байна. Судалгааны явцад цөөн нэр төрлийн ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлдэг хаягжилт тодорхойгүй байгууллага байна. Орон нутагт, алслагдмал дүүргүүдэд тогтсон суурьшилтай, нийлүүлэгч байгууллага байхгүй байх нь иргэдийг хот руу олон дахин явах, зардал их гарах, цаг хугацааны хувьд хүлээх зэрэг хүндрэлүүдийг дагуулж байна.

Ортопед, тусгай хэрэгслийн үнэ 2012 оноос хойш өөрчлөгдөөгүй бөгөөд иргэд зарим хэрэгслийг зөрүү мөнгө төлж авах тохиолдол нилээдгүй гарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгсэл 3 жил тутамд нэг олгож байгаа ба амархан багаддаг тул иргэд ихэнхдээ өөрсдөө худалдаж авч байна. СЗСҮТ-ийн очер дараалал их байдаг тул иргэд согог засах гутал, улавчийг авахын тулд хүлээх асуудал их үүсдэг.

Нийлүүлэгч байгууллага бүр төрөл бүрийн нурууны ширэн хамгаалалт олгодог ба иргэдээс зах зээлийн үнээс хэтэрхий өндөр үнэтэй хамгаалалт өгч байгаа талаар гомдол ирдэг. Ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагаас 30000-70000 төгрөгийн үнэтэй нурууны ширэн хамгаалалтыг олгож байгаа тохиолдол нилээдгүй гарч байна. Энэ нь ахмад настан бүр нурууны ширэн хамгаалалт авах, үйлчилгээг хавтгайруулах асуудлыг үүсгэж байна.

Сонсголын аппаратыг байгууллагууд өндөр үнэтэй оруулж ирдэг ба иргэд чанартай олон сувагтай, ус чийгний хамгаалалттай аппарат авахын тулд зөрүү мөнгө төлж байна.

Нийлүүлэгч байгууллагуудаас хүүхдийн хэрэгслүүд дээр мөн тэргэнцэр, суултуур, стомын уут, сонсголын аппарат зэрэг иргэдийн хамгийн их авдаг хэрэгсэл дээр үнийг зайлшгүй нэмэх шаарлагатай байгааг онцолсон. Дотоодын үйлдвэрлэгчид ортопед болон тусгай хэрэгсэл бүрт үнийг 15.0-250.0 төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай байгаа талаар үнийн саналаа өгсөн. Инфляцийн түвшин жил бүр өсч байгаа ч Ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ 2012 оноос хойш өөрчлөгдөөгүй байна. Иймд 2012 оны зарим хэрэгслийн үнийн дүнг инфляцаар засварлаж одоогийн худалдан авах чадварыг гаргахад сонсголын аппарат 558.3, суултуур 127.6, тэргэнцэр 239.2 төгрөг болж нэмэгдэж байна. ХБХ-ийн хэрэгслүүд дээр тэргэнцэр 957.0, тавцантай ширээ 255.2, алхуулагч 191.4 төгрөг болж нэмэгдэхээр байна.

5.2 Санал, зөвлөмж

Судалгааны үр дүнд дараах санал зөвлөмжийг боловсрууллаа.

- Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн системд үйлчилгээнд хамрагдсан иргэд ахмад настан, ХБИ-ээр ялгагдаж тайлан мэдээ гарч байгаа боловч ХБХ, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, насны ангилалаар харах боломжгүй байгаа тул сайжруулах;
- Үйлчилгээний талаарх мэдээллийг зөв түгээх;
- Ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээний журамд өөрчлөлт оруулахдаа ахмад настан, ХБИ, ХБХ-ээр олгох хугацаа, үнийн дүнг хэрэгсэл тус бүр дээр тодорхой ялгах, ХБИ, ХБХ-ийн бэрхшээлийн онцлогт таарсан хэрэгслийг олгодог байх;
-
- Шаардлагатай зарим тусгай хэрэгслийн үнийн дүнг нэмэгдүүлэх, зарим хэрэгслийг хасах;
- Нийлүүлэгч байгууллагуудын жагсаалт үүсгэхэд төрөлжсөн дэлгүүр, худалдааны төв, цахим хуудастай байх шаардлага тавих;

- Нийлүүлэгч байгууллагын нийлүүлж буй бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлага тавих;
- Нийлүүлэгч байгууллагад тавих хяналтыг сайжруулах;
- Үйл ажиллагааны хувьд зөрчилтэй, гэрээний үүргээ зөрчсөн байгууллагад хяналтыг тавьж, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах;
- Байгууллагуудын нийлүүлж буй бараа бүтээгдхүүнд чанар стандартыг тогтоох;
- Ортопед, тусгай хэрэгслийг олгохдоо төлбөр төлсөн баримтаар олгох, нэхэмжлэхээр олгох иргэдийг зааж өгөх /амьжиргааны түвшинтэй харьцуулж/;